АГУУЛГА

1. Төслийн танилцуулга 1
1.1. ТАЛБАЙН БАЙРШИЛ 2
2. Төсөл хэрэгжиж буй ОРОН нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга 4
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт 8
4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийн гол зорилт, хамрах хүрээ 8
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 11
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 22
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ 30
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ 31
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ 31
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 31
11. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 33
12. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 34
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ 10-37
Судалгааны арга зүй 10-37
Хөрсний үзүүлэлтүүдийг үнэлэх үзүүлэлтүүд мэдээлэл 10-38
Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэв шинж, түүний онцлог 10-38
Төслийн талбайд тархсан хөрсний өнөөгийн төлөв байдал 10-39
Хөрсний хээрийн судалгааны мэдээлэл, тэмдэглэл 10-41
Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэлийн мэдээлэл-1 DL23-03D-01 10-41
Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэлийн мэдээлэл-2 DL24-01D-01 10-42
Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэлийн мэдээлэл-3 DL24-02D 10-43
Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэлийн мэдээлэл-4 DL24-03D 10-44
Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэлийн мэдээлэл-5 DL24-04 10-45
Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэлийн мэдээлэл-6 сатр-2024 10-46
Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэлийн мэдээлэл-7 DL25-01D-01 10-47
Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэлийн мэдээлэл-8 DL25-01D-02 10-48
Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэлийн мэдээлэл-9 DL25-03 10-49
Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэлийн мэдээлэл-10 DL25-04 10-50
Хөрсний химийн задлан шинжилгээний дүн 10-52
Судалгааны цэгүүд дэх хөрсний үндсэн хэв шинж ба тэдгээрийн онцлог 10-53
Хөрсний механик бүрэлдэхүүн 10-55
Хөрсний ус-физик шинж чанар 10-55

ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН АГУУЛАМЖ 10-56
ЦАЙН ХУЖИРЫН БУЛАГ (DL25-01US) 10-60
ҮЕРТИЙН БУЛАГ (DL25-02US) 10-63
САЛАА БУЛАГ (DL25-03US) 10-66
ХАДНЫ БУЛАГ (DL25-04US) 10-69
ХАДНЫ БУЛАГ-2 (DL25-05US) 10-72
СЭРТЭНГИЙН БУЛАГ (DL25-06US) 10-75
ЦАГААН ХОНХОРЫН БУЛАГ (DL25-07US) 10-78
БОГД-IV ТАЛБАЙН УСАН ОРЧНЫ ХҮНД МЕТАЛЛЫН ШИНЖИЛГЭЭ 82
АМЬТНЫ АЙМАГ ТОДОРХОЙЛОХ АРГА ЗҮЙ 89
СУДАЛГААНЫ БАГАЖ ХЭРЭГСЭЛ 89
СУДАЛГААНЫ ҮР ДҮН 89
ХӨХТӨН 91
ШУВУУД 95
МӨЛХӨГЧ 100
УРГАМАЛЖИЛЫН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ 101
ДЭЛГЭР ХАЙГУУЛЫН ТАЛБАЙН УРГАМЛАН НӨМРӨГ 103
Төслийн талбайн зүйлийн бүрэлдэхүүн 104
Төслийн талбайн ургамлан бүлгэмдэл 105
DL25-01D-01 талбайн ургамлын бичиглэл 105
DL25-01D-02 талбайн ургамлын бичиглэл 107
DL24-01D-01 талбайн ургамлын бичиглэл 109
DL23-03D-01 талбайн ургамлын бичиглэл 111
Сатр-2024 талбайн ургамлын бичиглэл 113
DL24-03D талбайн ургамлын бичиглэл 115
DL24-04 талбайн ургамлын бичиглэл 117
DL24-02 талбайн ургамлын бичиглэл 119
DL25-03 талбайн ургамлын бичиглэл 121
DL25-04 талбайн ургамлын бичиглэл 123

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 126

15. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ 126

16. ДҮГНЭЛТ 128

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: Нүүрсний давхаргын метан хийн бүтээгдэхүүн хуваах гэрээт Богд-IV блокод хамаарах Дэлгэр талбайд нарийвчилсан хайгуул хийх төсөл

Төслийн үндэслэл: “Тахь ресурс” ХХК нь Нүүрсний давхаргын метан хийн онги V блокийн хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Ашигт малтмал, Газрын тосны газартай 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр НДМХийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа гүйцэтгэхээр “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” байгуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 57 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, Газрын тосны газартай Бүтээгдэхүүн хуваах гэрээт, Уул уурхайн, хүнд үйлдвэрийн сайдын А/618 тоот тушаалаар “Уламжлалт бус газрын тос буюу нүүрсний давхаргын метан хий” хайх 878 дугаартай аж ахуй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авсан хайгуулын компани юм.

Төслийн зорилго: “Тахь ресрус” ХХК нь Монголоос нүүрсний давхаргын метан хийг хайж, боловсруулан дэлхийн бусад улс орнуудад нийлүүлэх анхдагчдын нэг нь болох зорилготой.

Түүнчлэн Монгол орныхоо байгалийн нөөц баялаг муутай төвөөс алслагдмал газар нутгуудад шинэ техник, технологи болон эрчим хүчний шинэ эх үүсвэрийг нүүрснээс бусад эх үүсвэрээс гарган авч шийдвэрлэхээр ажиллаж байна.

Хэтийн төлөв: Монгол улс нь Байгалийн хийн асар их нөөц бололцоотой газар нутаг бөгөөд бид улс орныхоо ирээдүйг илүү өнгөлөг гэгээтэй болгохын зэрэгцээ өнөөдөр нийгэмд тулгамдаж буй олон чухал асуудлуудыг шийдвэрлэх гарц нь болно гэдэгтээ итгэлтэй байна. Үүнд:

- Эрчим хүчний аюулгүй болон хараат бус байдал;
- Хямд үнэтэй шатахуун;
- Хотуудын агаарын бохирдол болон үүнтэй холбоотой эрүүл мэндийн асуудлууд;
- Шинэ ажлын байр болон эрүүл аюулгүй амьдрах орчин;
- Эдийн засгийн тогтвортой байдал.

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага: “Тахь ресрус” ХХК нь Монгол улсын 5513618 бүртгэлийн дугаартай, 9011273066 тоот аж аухйн нэгжийн гэрчилгээтэй. НДМХ-н эрэл хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани юм.

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-7, Петровис компанийн байр.

1.1. ТАЛБАЙН БАЙРШИЛ

Бүтээгдэхүүн хуваах гэрээт Богд-IV блок нь Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Баянхонгор аймгийн Богд, Баянцагаан, Жинст, Баацагаан, Өлзийт, Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан, Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Чандмань, Бигэр, Халиун, Дэлгэр, Есөнбулаг, Баруунбаян-Улаан дэвсгэрийг хамарсан 25868.40 км2 талбайг эзлэн оршино. Талбайн булангийн цэгүүдийг зураг-1 болон хүснэгт-1-т үзүүлэв.

ЗУРАГ.1 БОГД-IV ХАЙГУУЛЫН ТАЛБАЙН БУЛАНГИЙН ЦЭГҮҮДИЙГ ХАРУУЛСАН ЗУРАГ

ХҮСНЭГТ.1 БОГД-IV БЛОКИЙН ТАЛБАЙД ХАМАРАХ АЙМАГ, СУМД

Д/д	Хот, аймаг	Талбайн хэмжээ(га)	Сум, дүүрэг	Талбайн хэмжээ(га)
1	Баянхонгор	1705120.13	Баацагаан	666011.24
2			Баян-Овоо	40030.83
3			Баянцагаан	337808.91
4			Богд	225447.33
5			Бөмбөгөр	9739.45
6			Бууцагаан	16479.15
7			Жинст	401597.78
8			Өлзийт	8005.4
9	Говь-Алтай	1024637.96	Бигэр	214178.54
10			Дэлгэр	356249.52
11			Есөнбулаг	40817.83
12			Тайшир	30125.14
13			Халиун	42867.25
14			Чандмань	340380.3
15			Эрдэнэ	19.39
16	Өвөрхангай	176480.73	Баруунбаян	175573.62
17			Нарийнтээл	907.11

Номенклатур: L-47-95, L-47-62, L-47-87, L-47-63, L-47-51, L-47-76, L-47-51, L-47-74, L-47-88, L-47-64, L-47-50, L-47-75, L-47-100, L-47-77, L-47-88, L-47-89, L-47-90, L-47-79, L-47-92, L-47-78, L-47-102, L-47-103, L-47-104, L-47-105, L-47-106, L-47-107, L-47-93, L-47-94, L-47-82, L-47-91, L-47-81, L-47-80, L-47-101

ЗУРАГ.2 БОГД-IV НДМХ ХАЙГУУЛЫН ГЭРЭЭТ ТАЛБАЙН БАЙРШЛЫН ЗУРАГ

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ОРОН НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын баруун хэсэгт орших НДМХ Богд-IV блокын талбай нь Говь-Алтай аймгийн 7 сум (Эрдэнэ, Дэлгэр, Бигэр, Халиун, Есөнбулаг, Тайшир, Чандмань), Өвөрхангай аймгийн 2 сум (Баруунбаян-Улаан, Нарийнтээл), Баянхонгор аймгийн 8 сум (Баацагаан, Богд, Баянцагаан, Жинст, Өлзийт, Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан), нийт 17 сумын нутаг дэвсгэр, 29,046.4 км^2 талбайг хамарч байна.

Физик газарзүйн мужлалт[1]: НДМХ Богд-IV талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалын хувьд Говийн их мужийн Хотгорын бүсшилтэй нутгийн Монгол өрнөд мужид, баруун хойд хэсгийн өндөрлөг уулстай хэсэгхэн газар нь Монгол Алтай мужид, баруунаас зүүн тийш суналттай уулс нь Говь-Алтайн мужид тус тус хамаарч байна. Нарийвчилсан хайгуул хийх 3-н талбайн хувьд:

- Дэлгэр талбай: Талбайн баруун урд тал нь Алтайн уулархаг их мужийн дэд муж болох Говь-Алтайн муж, Говь-Алтайн баруун тойрог, Талбайн баруун, хойд, зүүн тал Говийн их мужийн дэд муж болох Алтайн ар говийн муж, Их нууруудын хотгор;

- Чандмань талбай: Бүхэлдээ Алтайн уулархаг их мужийн дэд муж болох Говь-Алтайн муж, Говь-Алтайн баруун тойрог;

- Хулангийн шанд талбай: Бүхэлдээ Алтайн уулархаг их мужийн дэд муж болох Говь-Алтайн муж, Говь-Алтайн баруун тойрог;

ЗУРАГ.3 МОНГОЛ ОРНЫ ФИЗИК ГАЗАРЗҮЙН МУЖЛАЛ

[1] ***Физик газарзүйн мужлалт*** гэдэг нь газар орныг байгалийн бүхий л нөхцөл буюу геологийн бүтэц, хотгор гүдгэр, уур амьсгал, ус зүй, хөрс, ургамалшил, амьтны аймгийн хам бүрдлийн талаар өөр хоорондоо тодорхой ялгаатай хэсгүүдэд хуваах явдал юм.

Байгалийн бүс, бүслүүрээр[2] талбайн баруун хойд, баруун урд тал нь цөлжүү хээр, хээрийн, талбайн баруун, зүүн, хойд тал нь заримдаг цөлийн, урд нь хуурай хээрийн бүсэд хамаарна. Нарийвчилсан хайгуул хийх талбайнуудын хувьд:

- **Дэлгэр**: Талбайн баруун урд тал хээр, хойд болон зүүн тал нь цөлжүү хээрийн бүсэд;
- **Чандмань:** Талбайн баруун урд, урд талын бага хэсэг нь хуурай хээр, баруун, зүүн, хойд тал нь бүхэлдээ цөлжүү хээрийн бүсэд;
- **Хулангийн шанд:** Талбайн баруун урд үзүүр хуурай хээр, урд, зүүн урд үзүүр цөлжүү хээр, баруун, зүүн, хойд тал нь бүхэлдээ заримдаг цөлийн бүсэд;

Байгаль нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлалтаар талбайн баруун, зүүн, хойд талын хэсэг нь Алтайн ар говийн цөлөрхөг муж, урд тал нь Говийн Алтайн уулсын муж тус тус хамаарч байна.

ЗУРАГ.4 МОНГОЛ ОРНЫ БАЙГАЛИЙН БҮС БҮСЛҮҮР

Нарийвчилсан хайгуул хийх талбайнуудын хувьд:

[2] **Байгалийн бүс гэдэг** нь Дэлхийн бөмбөрцгийн хойд хагаст уур амьсгалыг бүрдүүлэгч нарны цацраг багасаж дулааны хэмжээ буурдаг учир өргөрөг бүрд байгалийн нөхцөл янз бүр болж бүсийн шинж чанартай болохыг хэлнэ. Монгол орон өндөр уулын болон уулын тайгын бүслүүр, ойт хээр, хээр, говь, цөлийн бүс гэсэн 6-н бүс, бүслүүрт хуваагддаг.

Дэлгэр: Богд-IV талбайн ихэнх хэсэг цөлөрхөг хээрд, Дэлгэр талбайн хайгуулын 1 шугам нь хээрийн бүсэд хамаарч байна. Цөлөрхөг хээрд хур тунадас багатайн дээр газрын гүний усны төвшин доор байрладаг тул ургамал ургах, хөрс бүрэлдэхэд таагүй нөхцөлтэй.

Монгол орны хэмжээнд цөлөрхөг хээр нь нийт 313059.22 км2 буюу манай орны нутаг дэвсгэрийн 20%-ийг эзлэн оршдог. Цөлөрхөг хээр нь говийн дорнод хэсэгт өргөн газрыг хамарч, Хангайн нурууны өмнүүр гарч, Нууруудын хөндийг дамжин Их нууруудын хотгорт өргөн зурвасаар шурган, цааш Алтайн нуруунд гүн нэвтэрч Чүйн хээрт хүрдэг байна. Цөлөрхөг хээрт говийн бор хөрс зонхилно. Зарим газар хужир, мараа ихтэй. Цөлөрхөг хээрийн хөрс ихэнх сайр чулуу элбэгтэй, газрын гадаргуугийн бараг 30-40% заримдаа түүнээс ч илүү хувь нь хайрга чулуун хучаастай байдаг. Хөрс нь тоосорхог, хөнгөн буюу дунд зэргийн шавранцар механик бүтэцтэй, ялзмаг багатай, карбонатлаг үе нэлээд дээр илэрдэг, бага зэрэг давсархаг, эсвэл огт давсархаг чанаргүй зэрэг онцлогуудтай. Давсны хүчилд бага зэргийн гүнээс буюу өнгөнөөсөө эхлэн буцална.

- **Чандмань болон Хулангийн шанд:** Талбай бүхэлдээ Говийн Алтайн уулсын мужид;

Монгол орны усны сав газар

- Хүйсийн говь-Цэцэг нуур
- Хяргас нуур-Завхан гол
- Бөөнцагаан нуур-Байдраг
- Орог нуур-Түй
- Таац
- Алтайн өвөр говь

Уур амьсгал: Тус нутагт өндөр уулын, хуурай хээрийн цөлөрхөг говь хээрийн уур амьсгал оршино. Чийглэгдүү хүйтэн тагийн болон дулаан говь цөлийн уур амьсгал, хагас цөл нутаг хийгээд өндөр уулын оройн хэсэгт бүрэлджээ. Өндөр уулын хуурайдуу хүйтэвтэр уур амьсгалтай.

Говь-Алтай аймгийн жилийн хамгийн хүйтэн сар нь аль ч нутгаараа нэгдүгээр сар байх бөгөөд ууландаа -17^{0}С…-19^{0}С, тал бүрээсээ өндөр уулс нуруугаар хүрээлэгдсэн хөндий, говь, хоолойгоор -20^{0}С…-23^{0}С хүрдэг байна. Жилийн хамгийн дулаан сар нь аль ч нутагт долдугаар сард байдаг бөгөөд агаарын дундаж температур нь ууландаа 15^{0}С, говь, хоолойгоор 20^{0}С...24^{0}С дулаан байдаг. Өвөл зуны дундаж температурын агууриг ууландаа 25^{0}С, говьдоо 47^{0}С, харин үнэмлэхүй их, бага температурын хувьд ууланд 75^{0}С, говьд 90^{0}С хүрч температурын хэлбэлзэл өндөр уулын бүсэд харьцангуй бага, говьд их байдаг байна.

Баянхонгор аймгийн нийт нутаг нь хангай, тал хээр, говь хосолсон нутагтай тул дулаан хүйтний хэлбэлзэл ихтэй сүүлийн жилүүдийн байдлаар нийт нутгаар жилийн дундаж агаарын температур дунджаар 2.0^{0}С дулаарсан хэдий ч улирлаар нь авч үзвэл: Тус аймгийн ихэнх нутгаар өвлийн улиралд 1.4-өөс 2.5 градус, хавар, зуны улиралд 0.2-оос 1.0 градусаар дулаарсан байна, нутгийн өмнөд хэсгээр өвлийн улиралд -0.2-оос -2.0 хүйтэрсэн хэдий ч зуны улиралд 2.0 градусаар дулаарч ажиглагдаж байна.

Гадаргын ус: Төслийн талбай орчим нь голын усны горимын хувьд хаврын шар ус, зуны хур борооны усаар үерлэдэг ба голын тэжээлийн 20% нь газар доорх ус, 25% нь цасны ус, 55%

нь хур борооны ус байна. Олон жилийн дундаж урсац буюу гадаргын усны урсцын модуль уулс хоорондох хөндийн шал, нам хотос газарт 0.1-1 л/с*км^2, газрын гадаргуугийн харьцангуй өндөршлийн зөрүү ихтэй газарт 1-2 л/с*км^2, гол мөрний нийлбэр урсац талбайн хойд, зүүн, баруун талд байх Бигэр нуурын орчмын уулс хоорондох хөндийн шал, нам хотос газруудад 20 л/с*км^2, Хулангийн шанд талбай орчимд 30-50 л/с*км^2, газрын өндөршлийн зөрүү ихтэй газарт буюу Чандмань талбай орчимд 50-100 л/с*км^2, Дэлгэр талбай орчимд 50-300 л/с*км^2 , хур борооны хамгийн их урсац судалгааны талбай хойд, зүүн талаар 10 мм-ээс бага, талбайн баруун хойд, урд талд 10-30 мм, голын сүлжээний нягтшил 0.01-0.05 км/км^2, шар усны үерийн хамгийн их урсац уулс хоорондох хөндийн шал, нам хотос газруудад 4 мм, газрын өндөршлийн зөрүү ихтэй газарт 20-40 мм, усны гадаргаас ууршиж ууршилт 5-9 дугаар сард 500-900 мм байна.

Газрын доорх ус: Төслийн талбайн газрын доорх усны нөхөн сэргээгдэх нөөц нь Байдраг, Түй, Таац гол болон зарим уул нуруудын хормой бэл газарт хуримтлагддаг байна. Богд-4 талбайд нөхөн сэргээгдэх нийт нөөц нь 397.1 м^3/жил, ашиглалтын баримжаат нөөц 248.93 м^3/жил байна.

Хөрсөн бүрхэвч: Монгол орны хөрс - газарзүйн мужлалтын хувьд төслийн талбай нь Говийн их мужийн Хотгорын бүсшилтэй нутгийн Монгол өрнөд мужид, баруун хойд хэсгийн өндөрлөг уулстай хэсэгхэн газар нь Монгол Алтай мужид, баруунаас зүүн тийш суналттай уулс нь Говь-Алтайн мужид хамаарна.

Богд-IV блокын талбайн газрын гадарга нь ерөнхийдөө бэсрэг уулс, ухаа гүвээ толгод, өргөн, нарийн хөндий, хужир марз бүхий хотгор хонхороос бүрдэнэ. Эндхийн уулс нурууд нь баруунаас зүүн тийшлэх тутам аажмаар намсдаг онцлогтой.

Хөрс нь элсэрхэг бүтэцтэй бөгөөд ус чийг ховордуу, харин агаарын температур овоо их нөхцөлд бүрэлдэн тогтжээ. Хүрэн хөрс зонхилж ухаа гүвээ болон уултай нутгаар дэлгэр тархана. Говийн нөлөөний улмаар цайвар хүрэн хөрс, говийн бор хөрстэй хослон тархсанаас гадна олон хотгороор хужирлаг хөрс, хужир марц түгээмэл байна. Үүний зэрэгцээгээр хөрсгүй элсэн тарамцаг байдаг.

Ургамлан нөмрөг: Монгол орны ургамал газарзүйн мужлалтаар төслийн талбай нь Евразийн хээрийн их муж буюу Төв азийн дэд их мужийн, Монголын хээрийн болон говийн умард цөлөрхөг хээрийн буюу Монгол Алтайн уулын дэд бага муж, Алтайн өвөр говийн говийн дэд бага мужид тус тус багтана. Алтайн өврөөр говийн ургамалтай. Ууландаа уулын хээр, хойд хэсгээрээ хээрийн ургамал тархжээ.

Сүүлийн 5-н жилийн мэдээнээс үзэхэд судалгааны талбайн ургамалжилт буурах хандлагатай байна. Энэ нь сүүлийн жилүүдэд орох хур тунадасны өөрчлөлт болон дулааралт эрчимтэй явагдаж байгаатай холбоотой.

Амьтны аймаг: Төслийн талбай нь амьтны аймгийн газарзүйн мужлалтаар Монгол-Түвдийн их муж Хээрийн ба ойт хээрийн дэд мужийн Монгол дагуурын тойрог, Говийн дэд мужийн Хойд говь, Говь-Алтайн тойрогт хамаарагдаж байна. /А.Г.Банниковын 1954/. М талбай нь Өвөрхангай аймгийн Гучин-Ус, Баруунбаян-Улаан, Баянхонгор аймгийн Богд, Жинст, Баацагаан, Баянцагаан Говь-Алтай аймгийн Чандмань, Бигэр, Дэлгэр сумын нутаг дэвсгэрийг хамрах бөгөөд Энэ бүс нутагт янгир, аргаль хонь, бор туулай, үлийн цагаан оготно, үнэг, хярс,

цагаан үен, мануул, шилүүс зэрэг хөхтөн амьтад, шилийн сар, хээрийн бүргэд, нөмрөг тас, адууч чогчиго, шоорон эвэрт болжмор, монгол болжмор зэрэг шувууд, цоохор хонин гүрвэл, могой гүрвэл, говийн гүрвэл зэрэг мөлхөгч амьтад түгээмэл тохиолдоно.

Богд-IV талбайд 47 зүйлийн хөхтөн амьтан, 159 зүйлийн шувуу, 8 зүйлийн мөлхөгч, хоёр нутагтан, 300 гаруй зүйлийн сээр нуруугүйтэн амьтад бүртгэгджээ.

Нийгэм, эдийн засгийн байдал: Говь-Алтай аймгийн Дэлгэр, Чандмань, Баянхонгор аймгийн Баацагаан, Баянцагаан сумдын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг статистикийн мэдээлэл болон асуумж судалгааны үр дүнд тулгуурлан хийгдсэн. Асуумж судалгааг блокын талбайд нутагладаг малчдын дунд хийсэн ба нутгийн ард иргэдийн төслийн талаарх бодол санал, хүлээлт, тэдний хэрэгцээ шаардлага болон амьдрал ахуйд гарч буй цаашид гарч болохуйц нөлөөллийг мэдэх зорилгоор явуулсан. Эдгээр төслийн явцад гарсан иргэдийн санал, төслийн үр дүнд үндэслээд төслийн улмаас сумын ард иргэдийн амьжиргаа нийгэм эдийн засагт гарч болохуйц эерэг сөрөг өөрчлөлт, нөлөөллийг тодорхойлж, эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх, сөрөг нөлөөллийг бууруулах санал зөвлөмжийг оруулсан болно.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Геофизикийн хайгуул болон өрөмдлөгийн ажлын үед автомашин, өрмийн тоног төхөөрөмж зэргийг тээвэрлэх, байршуулахад олон салаа зам үүсэх магадлалтай, үүний улмаас газрын гадарга талхлагдан хөрс, ургамлын бүрхэвчид өөрчлөлт оруулна.

Хайгуулын үед үйл ажиллагааны улмаас мал, амьтны тархац, шилжилт хөдөлгөөн, идэш тэжээлийн байдалд сөрөг нөлөөлөл учирч магадгүй.

Шатахуун, тослох материал, хог хаягдлаас хөрс бохирдсоноос хөрсний үржил шим алдагдах сөрөг нөлөөлөл учирч болзошгүй.

Хүн техникийн хөдөлгөөн, дуу чимээний улмаас ан амьтад үргэж, дайжин хэвийн байдал алдагдаж болзошгүй.

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчныг хамгаалах зорилго, зорилт

Богд-IV талбайд нүүрсний давхаргын метан хийн 2025 оны хайгуулын ажил гүйцэтгэх төслийн үед гарах сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг 2025 оны Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хүрээнд авч хэрэгжүүлж, биелэлтийг БОМТөлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, Монгол улсад мөрдөгдөж байгаа байгаль орчны хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагыг мөрдлөг болгон төлөвлөгөөний биелүүлэхийг тайлагнах гол зорилго болсон.

Хамрах хүрээ

Монгол улсын баруун хэсэгт орших Газрын Тосны НДМХ Богд-IV блокын талбай нь Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай аймгийн 17-н сумдын 29,062.4 км^2 газар нутгийг хамрах ба 2025 онд дараах нарийвчилсан хайгуулын 1 талбайг өмнөх хайгуул судалгааны үр дүнд үндэслэн өрөмдлөгийн ажил, лабораторийн шинжилгээнүүд зэрэг ажлуудыг хайгуулын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийсэн.

- Дэлгэр талбай нь Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын нутаг дэвсгэрт байрлах ба нийт 483.7 км^2 талбайг хамрана.

4.1. ХАЙГУУЛЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН АРГА, АРГАЧЛАЛ

2025 оны хайгуулын ажлыг бэлтгэл ажил, цооног өрөмдлөгийн ажил, цооногийн геофизикийн судалгаа (каротаж), нүүрсний давхраасын нэвчүүлэмжийн туршилтууд, лабораторийн ажил гэсэн үндсэн ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

4.1.1. БЭЛТГЭЛ АЖИЛ

Хээрийн судалгааны өмнөх шатанд дараах бэлтгэлүүдийг хангаж ажилласан. Үүнд:

- Төслийн талбайд өмнө нь гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлуудын тайлан материалуудтай танилцан одоо мөрдөгдөж байгаа “Газрын тосны тухай хууль”, “Ашигт малтмалын тухай хууль”, “Газрын хэвлийн тухай”, “Усны тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн заалтуудыг чанд мөрдөн үйл ажиллагаагаа явууллаа. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан болон Байгаль орчинд нөлөөлөх байдлыннарийвчилсан үнэлгээний тайланг холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн. Тухайн жилд хэрэгжүүлэх БОМТөлөвлөгөөг БОУАӨЯ-аар батлуулж холбогдох Төрийн байгууллагуудад тус бүр нэг нэг хувийг хүргүүлсэн.
- Богд-IV хайгуулын талбайд геофизикийн судалгааны ажлыг гүйцэтгүүлэхээр тендер зарлан “Татах хүч” ХХК-г шалгаруулж гэрээ байгуулсан.
- Богд-IV хайгуулын талбайд цооногийн өрөмдлөгийн ажлыг гүйцэтгүүлэхээр тендер зарлан “Топ Даймонд Дриллинг” ХХК-г шалгаруулж гэрээ байгуулсан.
- Өмнөх судалгааны бүх мэдээ материалтай нарийвчлан танилцан дүн шинжилгээ хийж, хээрийн ажлын үед хэрэглэгдэх байр зүйн зураг, ашигт малтмал, геологийн зургуудыг хээрийн ажилд хэрэглэгдэх хэмжээгээр хэвлүүлж бэлтгэсэн. Хээрийн нөхцөлд ажиллах боловсон хүчний асуудлыг шийдсэн.
- Хээрийн ажилд хэрэглэгдэх эд аж ахуйн болон багаж хэрэгслийг компанийн агуулахаас авч зарим байхгүй хэрэгслүүдийг худалдаж авсан.

- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн төлөвлөгөө зохион БОУАӨЯ-аар батлуулж холбогдох Төрийн байгуулагуудад хүргүүлэн талбайн ерөнхий байдалтай урьдчилан танилцсан.

4.1.2. ӨРӨМДЛӨГИЙН АЖИЛ

Энэхүү цооногийг өрөмдөх гол зорилго нь нүүрсний давхаргаас өндөр чанартай чөмгөн дээж авах, сонгосон инвервалын дээжийг ашиглан тухайн ордын хийн агууламж, шинж чанарыг тодорхойлох юм.

Нүүрсний давхаргын метан хийн эрлийн болон десорпц тест хийх цооногийг өрөмдөхдөө Австрали улсын CBM өрөмдлөгийн стандартыг баримталж өрөмдөнө. Тухайн өрөмдлөгийн онцлог нь:

- Цооногийн тогтвортой байдлыг дээд зэргээр хангаж явах;
- Эрдсийн онцлогоос шалтгаалан чөмгөн дээжинд өрөмдлөгийн явцын нөлөөллийг боломжит доод түвшинд барих;
- Нүүрсний давхаргаас чөмгөн дээжний гарцыг хамгийн дээд боломжит дээд түвшинд байлгах.

Өрөмдлөгийн ажлын баримтжуулалтыг Австрали улсын Geogas компаний аргачлал зааварчилгаа болон Монгол улсад мөрдөгдөж буй хайгуулын арга аргачлал, заавар журмын дагуу бүрдүүлж анхдагч баримт материал, фото зураг зэргээр баталгаажуулан тусгай сан үүсгэн хадгална.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Зардал /мян.төг/	Биелэлт	Баримталж ажилласан эрх зүйн баримт бичиг, стандарт
	1	2	3	4	5
1.	Өрөмдлөгийн машин бусад машин техникийн шаталтаас агаар мандалд хүлэмжийн хий ялгарах	Түлшний шаталтын тоног төхөөрөмжийн тохиргоо, үйлчилгээг тогтмол хийж, бүртгэлжүүлж тэмдэглэх, Бүх машин техникийг үзлэгт тогтмол оруулах, дизель түлш ашигладаг дотоод шаталт хөдөлгүүрүүд болон машинуудыг ашиглаагүй үед сул асаалттай байлгахгүй байх, шаардлага хангахгүй байгааг нь шинэчлэх	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Төслийн талбайн агаарын сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор туслан гүйцэтгэгч компанид ашиглагдах тээврийн хэрэгсэлүүд үзлэг оношилгоонд орсны дараа хайгуулын ажилд ажилд гаргасан. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан.	"Агаарын тухай" болон "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хууль; MNS 4585:2016 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 5885:2008 "Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага" MNS ISO 4227:2002 "Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө" MNS 6063:2010 "Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ"
	Тээврийн хэрэгсэл, өрмийн хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт бий болох	Геофизикийн судалгааны ажлын үед тоосжилтыг бууруулах зорилгоор машины хурдны хязгаарыг тогтоож, хөдөлгөөнд хяналт тавих, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоог тогтмол хийж, хөдөлгүүрээс гарах хорт хийн ялгарлыг орчны хяналт шинжилгээний хүрээнд хэмжилт хийсэн. Хайгуулын ажлын үед машины хурдны хязгаарыг тогтоож, хөдөлгөөнд хяналт тавих ажлыг газар дээр нь хийж ажилласан.	
		Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгааг хийх (замын арчилгааг тогтсон хувиарын дагуу хийх)	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Нэг замын бодлого баримтлаж ажилласан. Замын тоосжилтыг бууруулах зорилгоор тээврийн хэрэгслээс болоод хуурайшилттай үед замын усалгааг хийж ажилласан.	
2.	Гадаргын ба газрын доорхи усны нөөц хомдох, усны чанар алдагдаж болзошгүй	Нарийвчилсан хайгуул хийх талбайд байх малын хөлөөр бохирдолд өртөж, ундарга нь дарагдаж болзошгүй булгийн эхийг хамгаалах, эрүүл ахуйн дэглэмийн бүсийг тогтоох	Үйл ажиллагааны зардлаар	Нарийвчилсан хайгуул хийх талбайд байх малын хөлөөр бохирдолд өртөж, ундарга нь дарагдаж болзошгүй булгийн эхийг хамгаалах ажлыг Говь-Алтай аймгийн Байгаль орчны газартай тус асуудлаар санал солилцож, ирэх онд	Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн

				тооцоо сдалгаатайгаар хийж гүйцэтгэхээр тохирсон байна.	дэглэмийг мөрдөх журам MNS5850:2019, MNS6148:2010, Арга хэмжээний талаарх зааварчилгаа
		Шатах тослох материал хөрсөнд алдагдахаас сэргийлэх үүднээс судалгааны багт сургалт, сурталчилгаа хийх	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Шатах тослох материал хөрсөнд алдагдахаас сэргийлэх үүднээс судалгааны ажил эхлэхийн өмнө сургалт зохион байгуулсан. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан.	
3.	Хөрсөн бүрхэвч эвдэгдэх, доройтох, нөлөөлөлд өртөх	Өрөмдлөгийн ажлын дараа талбайг засч тохижуулах, тэгшлэх, өмнөх байдалд нь дүйцүүлэх	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Хайгуулын өрөмдлөгийн ажил дуусч кемп буусны дараа хайгуулын талбайг засч стандартын дагуу тэгшлэн орон нутагт хүлээлгэн өгсөн. Цооногуудын техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008
	Өрөмдлөгийн хаягдал шавраар хөрсөн бүрхэвч бохирдох	Хатуу, шингэн хог хаягдлыг төвлөрсөн хог хаягдлын цэг рүү зохих журмын дагуу ачиж зайлуулах	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Хайгуулын ажил дууссаны дараа түр кэмпийн хатуу, шингэн хог хаягдлыг ангилан ялгаж, сумын төвлөрсөн хогийн цэгт хаясан.	MNS 5850: 2019 Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Олон салаа зам гаргахгүй байх	Геофизикийн судалгааны үед олон салаа зам гаргаж бэлчээрийг доройтуулахаас сэргийлэх талаар ажилчдын дунд сургалт явуулах, үйл ажиллагаанд хяналт тавих	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Хээрийн судалгааны ажил эхлэхээс өмнө ажилчдад сургалт зохион байгуулж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллсан. Нэг замын бодлого баримтлан ажилласан.	Байгаль хамгаалах тухай хууль
	Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарсан бохир усыг ил задгай асгах	Ажилчдын кемп орчимд овор багатай зөөврийн ёнкост суурилуулах, зориулалтын машинаар соруулж аймгийн цэвэрлэх байгууламжид нийлүүлэх эсвэл био 00 ашиглах	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Хээрийн судалгааны үед зөөврийн био жорлон ашигласан. Гэвч энэ жилийн хувьд хайгуулын ажил хэт орой хүйтний улиралд эхлэсэн тул хэт хүйтэрснээс зарим үед зөөврийн био жорлон ажиллахгүй хөлдөх асуудал бидэнд хайгуулын дунд шатанд тулгарсан. Энэ үед нүхэн жорлонг ашиглаж, хайгуулын ажил дуусмагч зориулалтын машинаар соруулж цэвэрлэсэн.	Байгаль хамгаалах тухай хууль MNS5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ
	Үйл ажиллагаанд ашиглах тээврийн хэрэгслээс тос масло асгарах, гоожих	Үйл ажиллагаа явуулах үед тос, масло асгарахаас урьдчилан сэргийлж элс, spill kit ашиглах /бэлэн байдалд байлгах/ зэргээр	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх	Иж бүрдлийг хайгуулын түр кэмпэд бэлэн байлгаж байсан ба тогтмол хяналт тавьж ажилласан.	MNS 5850:2019

		хөрсийг саармагжуулж, цэвэрлэх , хүнд металлын дээж авч хяналт тавих	компаний гүйцэтгэлд тусгагдсан.		
	Хайгуулын болон өрөмдлөгийн ажлын үед хөрс, газрын гадарга элэгдэлд орох	Хээрийн анги болон байгууламжуудыг барих явцад эвдэрсэн талбайн хөрсийг нөхөн сэргээж орон нутагт хүлээлгэн өгөх	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Цооногуудын техникийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу туслан гүйцэтгэгч компаний хийж гүйцэтгэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/439 тоот тушаалын дагуу “Тусгай зөвшөөрөлтэй талбайд нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авах акт” үйлдэн тухайн сумаас байгуулагдсан ажлын комисст хүлээлгэн өгсөн.	MNS5546:2005 Бэлчээрийн газрын хөрсний элэгдэл эвдрэл, ургамлын талхлагдлыг тогтоох ерөнхий шаардлага
4.	Хээрийн анги байгуулах сорьцлолт, дээжлэлт хийх, тээврийн хөдөлгөөнөөр тухайн газрын ургамлан нөмрөг устах талхлагдах	Газар хөндөлтөд сорьцлолт, дээжлэлт хийхдээ аль болох бага эвдрэл доройтол үүсгэх	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Хээрийн анги байгуулагдахаас өмнө Дэлгэр сумын Засаг даргын захирамжаар түр кемп байрлах газрын зөвшөөрлийг авсан. Тухайн зөвшөөрөл авсан газрын ургамлан нөмрөг, хэв шинжийг тухайн сумын Багийн Засаг дарга болон байгаль орчны хяналтын улсын байцаагчийн хамт газар дээр нь очиж ажиллан хүлээн авсан.	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012 7.2.4-р заалт
	Ургамлан нөмрөг, ховор ургамлууд нөлөөлөлд өртөж доройтох, дарагдах устах	Ургамлын бүрхэц, бүлгэмдэл, зүйл, бэлчээрийн ургамлын гарц, биомассыг тодорхойлох, сөрөг нөлөөллийг бууруулах урьдчилан сэргийлэх зорилгоор тоосжилтонд өртөж байгаа талбайд усалгаа хийх	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Нэг замын бодлого баримтлаж ажилласан. Замын тоосжилтыг бууруулах зорилгоор тээврийн хэрэгслээс болоод хуурайшилттай үед замын усалгааг хийж ажилласан.	Байгаль хамгаалах тухай хууль, Ургамлын тухай хууль
5.	Амьтны аймаг	Ховор болон нэн ховор амьтад тэдгээрийн нүүдэл, шилжилт хөдөлгөөн, мөн төслийн талбайн гадна болон дотор анхаарал болгоомжтой зорчих талаар жолооч нарт сургалт явуулах	Тухайн зардал нь туслан гүйцэтгэх компаний гүйцэтгэлд тусгагдсан.	Хээрийн судалгааны ажил эхлэхийн өмнө сургалт зохион байгуулж, ажилчдад заавар, зөвлөмж өгч ажилласан.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Амьтны тухай хууль
		Амьтдын шилжилт хөдөлгөөний үеэр хурдны хязгаарыг бууруулж, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах	ОХШХ-ийн зардалд тусгагдсан	Хээрийн судалгааны ажил эхлэхийн өмнө нийт ажилчдын ХАБЭА болон БО-ны сургалт зохион байгуулж, ажилчдад заавар, зөвлөмж өгч ажилласан.	
		Амьтны ажиглалт судалгаа, мониторинг хийх, тоо толгойг бүртгэх	ОХШХ-ийн зардалд тусгагдсан	ОХШ-ний ажлын хүрээнд тус ажил хийгдсэн.	

- 2025 оны Богд-Ⅳ блокийн хайгуулын талбайд нийт 37 мониторингийн цэгүүдэд усан орчин, агаарын чанар, ургамал, хөрсний бичиглэл үйлдэн хөрсний зүсэлт, хөрсний хэв шинж тус бүрээс морфологи бичиглэлийг хээрийн нөхцөлд тодорхойлж, хөрсний үе давхарга бүрээс лабораторийн задлан шинжилгээнд зориулан дээж авч ШУА Газарзүй-Геоэкологийн хүрээлэн болон “Алс” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораториудад шинжлүүлсэн.
- Агаарын чанарыг шинжилгээг өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор агаар дахь бохирдуулагч бодисуудыг агууламжийг MNS 0017-2-5-12:2021, MNS 0017-2-5-11:2021 стандартуудын дагуу хэмжин, судалгааны мэдээллийг үндэслэн тооцон гаргав.
- Төслийн талбай орчмын амьтны аймгийг төслийн талбай орчмын амьтдын тархалтын мэдээ болон хээрийн судалгааны туршид тохиолдсон амьтдын ул мөр, үүр, ялгадас, нүдэн тооллогоор тогтоолоо.
- Усан орчны шинжилгээг MNS4586:2024 Усан орчны чанар. Ерөнхий шаардлага, MNS6148:2010 Усны чанар Газрын доорх бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартуудтай харьцуулан дүн шинжилгээг хийв.
- Статистик боловсруулалтыг Past 4.10 программаар боловсруулав. Төсөл хэрэгжих Дэлгэр сумын агаарын температурын параметрийг NASA хиймэл дагуулын мэдээ POWER Data access viewer v2.0.0 программ, Цаг уур орчны шинжилгээний газрын Архив мэдээллийн сан Говь-Алтай аймаг Есөнбулаг станцын 2023-2024 оны цаг уурын мэдээг ашиглав. Ашигласан бүтээлийн жагсаалтыг Mendeley программын дагуу боловсруулав. Төслийн талбай орчмын мэдээллийг ArcMap 10.5 программаар боловсруулж өмнөх судалгааны материал болон зарим байгалийн бүрэлдэхүүн хэсгийг зайнаас тандан судалгааны арга газарзүйн мэдээллийн системд тулгуурлан боловсруулаа.

5.1 ГАЗАР АШИГЛАЛТ БА ХӨРСӨН БҮРХЭВЧ:

2025 оны Богд-IV блокийн хайгуулын талбайд өрмдлөгийн ажлыг туслан гүйцэтгэгч компани 20 орчим хүн, гүйцэтгэгч компани 2-3 хүн, орон нутгаас хүн авч ажилуулсан. Ингэхдээ Дэлгэр сумын Засаг даргын захирамжаар дараах түр кемп байрлах газрын зөвшөөрлийг авсан бөгөөд гэрээний үүргийн дагуу хайгуулын ажил явагдах үед гэрээг байгуулж гэрээний дагуу зохих төлбөрийг төлж ажилласан.

БАТЛАВ:
ГОВЬ-АЛТАЙ АЙМАГЫН ДЭЛГЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГА ..... Ж.ЭЛБЭГДОРЖ

ХАЙГУУЛЫН ӨГӨМДӨГӨЛИЙН ТҮР КЕМП БАЙРЛАХ ЗОРИУЛАЛТААР
ГАЗАР АШИГЛАХ ГЭРЭЭ

2025 оны 03 сарын 27 өдөр ... Дэлгэр сум

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь хэсэг, Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргын 2025 оны ..... дугаар захирамж ..... хэрэгжүүлэх ..... тоот гэрээгээр түр эзэмшлийн газар ашиглуулагчийг төлөөлөн Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын газрын даргын Сэдэвсүрэнгийн Нарангерел гэдэг хаягтайгаас ..... 9919097258 тоот утсыг бүртгэлийн гэрчилгээ, 5513618 тоот данснаасаа дүгнэгдэн "Тахь ресурс" ХХК-ийн Түшээтэй захирал Д.Энхжаргал цаашид "Газар ашиглуулагч" гэх нэрлэн гэрээг байгуулав.

1.2. Энэхүү гэрээний хаяг, гарын үсэг байрлах, хэлсэн хэлц, хаяг, зөвшөөрөгдөх харуулах мэдээлэл хаягчилна.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Гэрээ хугацаанд олгосон газрын нийт хэмжээ 1 га байна.

2.1.1 Талбайн байрлал

Байршил	Хязгаар цэгийн бөөрөнхий координат	
	Уртраг	Өргөрөг
Говь-Алтай аймгийн Дэлгэр сум	97° 14' 41.43"	46° 14' 31.81"
	97° 14' 45.10"	46° 14' 31.82"
	97° 14' 45.11"	46° 14' 28.65"
	97° 14' 41.44"	46° 14' 28.64"

Дэлгэр сумын орон нутгийн талбайн зургаатайн цэг		
Дд	Уртраг	Өргөрөг
1	97° 19' 46.306"	46° 15' 0.935"
2	97° 19' 45.152"	46° 11' 8.273"

2.2 Монгол Улсын Засгийн газрын 2018 оны өдөр гаргасан тогтоол, зарлиг, бүс, суурь хөгжлөө, газрын талбайн хамгаалах тогтоол гуай 182 дугаар тогтоолыг удирдлагаа газрын талбайн хэмжээ ба
Нэгжийн үнэ нь 1600 төгрөг /нэг мянга зуун алав төгрөг/

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ГАЗАР АШИГЛУУЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛӨН: Дэлгэр сумын газрын даргын ..... /С.Нарангерел/

ГАЗАР АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛӨН: "Тахь ресурс" ХХК-ийн Түшээтэй захирал ..... /Д.Энхжаргал/

ЗУРАГ. 5 ДЭЛГЭР СУМТАЙ ХИЙСЭН ГАЗРЫН ГЭРЭЭ

ЗУРАГ. 6 ХАЙГУУЛЫН КЕМПИЙН ЗУРАГ

ЗУРАГ. 7 ТҮР КЕМПИЙН ЕРӨНХИЙ ХАРАГДАХ БАЙДАЛ

Талбайн хэмжээнд авсан 10 цэгийн дээжнээс хөрсний хүнд металлын шинжилгээг 10 дээжид шинжлүүлсэн бөгөөд Монгол улсын хөрс бохирдуулагч бодис, элементийн MNS 5850-2019 стандартын холбогдох үзүүлэлтүүдтэй харьцуулан дүгнэлээ.

Монгол улсын стандартад хамаарах 11 элементийг стандартын хүлцэх, хортой, аюултай агууламжийн зэрэгтэй харьцуулан үзэхэд хайгуул судалгааны талбайн хэмжээнд хөрсөн дэх элементүүдийн агууламж хүлцэх агууламжаас бага түвшинд байгаа нь тухайн хөрс, чулуулгийн геохимийн аномаль бохирдол болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй бохирдол байхгүйг илтгэж байна.

Хөрс бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ гэж хөрс бохирдуулах бодисын хөрсөнд байж болох хамгийн их хэмжээ. Тухайн ангиллын хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан тохиолдолд тухайн хөрсийг бохирдсон гэж тооцно.

ХҮСНЭГТ 3. ХӨРСНИЙ БОХИРДЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

Дээж/хүнд металлууд	As	Cd	Co	Cr	Cu	Mo	Ni	Pb	Sr	V	Zn
DL23-03D-01(2025)	8	<0.5	17	72	31	1	68	9	140	67	69
DL24-01D-01(2025)	11	<0.5	16	74	33	1	62	7	255	62	64
DL24-02D	8	<0.5	16	57	30	1	57	11	95	67	72
DL24-03D	11	<0.5	16	78	26	1	66	10	164	63	53
DL24-04	10	<0.5	17	74	32	1	66	9	108	74	68
Camp-2024	8	<0.5	18	73	34	1	68	12	66	69	76
DL25-01D-01	8	<0.5	16	58	31	1	63	11	62	65	74
DL25-01D-02	9	<0.5	15	56	29	1	60	11	54	69	74

DL25-03	9	<0.5	16	54	27	1	72	8	58	68	66
DL25-04	7	<0.5	17	69	26	1	80	10	43	65	72
Хүлцэх агууламж MNS5850:2019	20	3	50	150	100	5	150	100	800	150	300
Элсэрхэг хөрсний хүлцэх агууламж MNS5850:2019	10	1	30	60	60	2	60	50	600	100	100

Богд-IV талбайн 10 цэгийн хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хэмжээнд буюу бохирдолгүй байна. Богд-IV талбайн онцгой хортой органик биш бохирдуулах бодисод хар тугалга (Pb), кадмий (Cd), хүнцэл (As), хром (Cr), байна. Эдгээр нь амьд организд учруулах хор нөлөө ихтэй, амьд организмд их хэмжээгээр орсон тохиолдолд өвчин үүсгэх улмаар үхэлд хүргэх аюултай бөгөөд төслийн талбайн хувьд стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан үзүүлэлтгүй байна.

Хөрсний хүнд металлын шинжилгээг “Алс групп” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн ба MNS5850:2019 стандарттай харьцуулахад Богд-IV талбайн хөрсөн дэхь элементүүдийн агууламж стандартын хүлцэх агууламжаас бага түвшинд буюу бохирдолгүй байна.

5.3 УСАН ХАНГАМЖ:

Хайгуулын өрөмдлөгт ашиглагдах ус ашиглах дүгнэлтийг Говь-Алтай аймгийн Байгаль орчны газраар гаргуулж, дүгнэлтийн хүрээнд Дэлгэр сумын Засаг даргатай ус ашиглах гэрээг байгуулж ажилласан. Усны дүгнэлтийн дагуу технологийн үйл ажиллагаанд ашиглагдах усны төлбөрийг Говь-Алтай аймаг, унд ахуйн, хэрэглээний усны төлбөрийг сумын ус ашиглах төлбөрийн санд байршуулсан.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭЛГЭДЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР

2025.05.29 № 196

ТАХЬ РЕСУРС ХХК

Монгол улсын "Усны тухай" хуулийн 4 дүгээр бүлгийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалт, танай газрын 42/25 дугаар албан хүсэлт, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Хайгуулын ажлын төлөвлөгөө, цахим лаалгаа зарлиг үндэслэн Дэлгэр сумын нутаг Богд-IV дугаар хайгуулын талбай эзэмшигч "ТАХЬ РЕСУРС" ХХК-ний 2025 онд эрэл хайгуулын зорилалтаар ус ашиглуулах дүгнэлтийг гарган хүргүүлэв.

Хавсралт.....хуудастай

Хүлээн авсан: Дэлгэр сумын Засаг даргад Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11-д заасны дагуу гэрээ байгуулж ажиллана уу.

ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.СОДМАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр Дугаар А/96 Алтай хот

1.Аж ахуйн нэгж байгууллага, хаяглалт нэр хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар. "Тахь Ресурс" ХХК. Гүйцэтгэх захирал: Д.Энхжаргал. Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьяан гүний, Хан-Уул цамхаг 502 тоот, утас:70116125, 88005430 Улсын бүртгэлийн дугаар 9016007258, регистрийн дугаар 8513618

2. Төслийн нэр, байршил. Говь-Алтай аймгийн Бигэр, Дэлгэр, Есонбулаг, Тайшир, Хөлөгт, Чандмань, Эрдэнэ сумын нутаг орших "Богд IV" хортой талбайн Дэлгэр сумын талбай нь Алтай хотоос 105 километрийн зайд, Хөрөг нуур-Зарханы голын сав газарт хамаардаг.

3.Төсөл хэрэгжүүлэх. "Тахь Ресурс" ХХК

4.Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /Б,У/. Уламжлалт бус газрын тос хайх тусгай зөвшөөрөлтэй. Аж ахуйн нэгж байгууллага 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/25 дугаар тушаалаар олгосон Сойёо /Дэлгэр сум 356249.52 га талбай/

Цэг	Өргөрөг	Уртраг	Цэг	Өргөрөг	Уртраг
1	46° 50' 00.000"	97° 05' 06.940"	34	45° 46' 37.907"	97° 52' 58.746"
2	46° 28' 53.760"	97° 05' 06.940"	35	45° 46' 18.583"	97° 50' 41.431"
3	46° 28' 53.760"	97° 11' 10.680"	36	45° 46' 26.797"	97° 50' 52.376"
4	46° 25' 55.200"	97° 11' 10.680"	37	45° 49' 42.589"	97° 42' 57.600"
5	46° 25' 55.200"	97° 12' 47.160"	38	45° 52' 04.800"	97° 42' 57.600"
6	46° 21' 51.840"	97° 12' 47.160"	39	45° 52' 04.800"	97° 40' 16.200"
7	46° 21' 51.840"	97° 16' 56.640"	40	45° 55' 48.000"	97° 40' 16.200"
8	46° 20' 00.000"	97° 16' 56.640"	41	45° 55' 48.115"	97° 33' 33.740"
9	46° 20' 00.000"	97° 27' 51.480"	42	45° 57' 31.354"	97° 33' 31.781"
10	46° 17' 49.800"	97° 27' 51.480"	43	45° 57' 31.182"	97° 37' 56.475"
11	46° 17' 49.800"	97° 32' 19.320"	44	45° 56' 12.755"	97° 37' 58.387"
12	46° 15' 44.400"	97° 32' 19.320"	45	45° 56' 11.303"	97° 39' 57.756"
13	46° 12' 44.400"	97° 36' 21.840"	46	45° 56' 57.868"	97° 39' 57.327"
14	46° 12' 07.560"	97° 36' 21.840"	47	45° 56' 57.868"	97° 30' 00.001"
15	46° 12' 07.560"	97° 36' 36.760"	48	45° 0' 59.924"	97° 30' 00.001"
16	46° 10' 00.120"	97° 36' 36.760"	49	45° 0' 04.784"	97° 22' 30.001"
17	46° 10' 00.120"	97° 49' 59.880"	50	45° 0' 34.115"	97° 22' 30.001"
18	45° 51' 10.911"	97° 49' 59.880"	51	45° 0' 31.197"	97° 17' 23.556"
19	45° 51' 10.911"	97° 47' 46.457"	52	45° 0' 06.908"	97° 17' 22.801"
20	45° 50' 00.000"	97° 46' 03.800"	53	45° 0' 06.000"	97° 10' 00.000"
21	45° 50' 00.000"	97° 52' 30.000"	54	45° 0' 54.844"	97° 10' 00.000"
22	45° 48' 25.160"	97° 52' 30.001"	55	45° 0' 59.828"	97° 10' 30.000"
23	45° 48' 21.960"	98° 00' 56.800"	56	45° 10' 00.000"	97° 10' 30.000"
24	45° 48' 21.960"	98° 07' 32.800"	57	45° 10' 00.000"	97° 07' 27.136"
25	45° 48' 24.120"	98° 07' 32.800"	58	45° 10' 36.137"	97° 00' 55.556"
26	45° 48' 24.120"	98° 10' 06.480"	59	45° 11' 15.985"	96° 54' 15.556"
27	45° 48' 24.048"	98° 10' 06.480"	60	45° 12' 20.911"	96° 42' 54.001"
28	45° 48' 24.001"	98° 27' 20.800"	61	45° 15' 27.360"	96° 44' 05.144"
29	45° 45' 19.908"	98° 27' 22.968"	62	45° 27' 27.360"	96° 44' 16.190"
30	45° 45' 19.908"	98° 27' 21.832"	63	45° 27' 27.360"	96° 43' 10.330"
31	45° 43' 32.880"	98° 19' 43.359"	64	45° 28' 51.197"	96° 43' 10.330"
32	45° 42' 01.356"	98° 18' 58.919"	65	45° 30' 00.000"	96° 43' 35.130"
33	45° 42' 54.696"	98° 02' 37.389"	66	45° 30' 00.000"	97° 02' 55.546"

ЗУРАГ.8 УС АШИГЛАХ ДҮГНЭЛТ

ЗУРАГ. 9 ДЭЛГЭР СУМЫН УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Усан орчны мониторингийн судалгааг нийт 7 булгийн усны дээжийг шинжлүүлсэн. Уг шинжилгээний дүнг Усны орчны чанар. Ерөнхий шаардлага MNS 4586:2024 стандарттай харьцуулахад Үертийн булаг $46^0$10’52”/ $97^0$5’5”, Сэртэнгийн булаг $46^0$10’9”/ $97^0$12’50” стандартын шаардлага хангаж байгаа боловч Сэртэнгийн булгийн усны хүнд металлын шинжилгээгээр Хүнцэл (As) зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлттэй байна.

Шалтгаан нь: Баруун Монголын томоохон нуурууд, зарим голын усны микроэлементийн агуулга дахь уран, түүнийг дагалдаж үүсдэг *хүнцэл,* литий зэрэг хорт элементийн бохирдолтын эх, үүсвэр нь маагмын чулуулаг, ашигт малтмалын орд, илрэлүүдтэй холбоотой бөгөөд уулын чулуулгийн элэгдэл, бутралын геологийн үйл явцтай холбож тайлбарладаг. *(Баруун монголын эрдэсжилттэй нуурууудын усны хорт элементийн экогеохимийн судалгаа, 2013)*

Бусад булгийн хувьд магнийн ион, нитритийн азот стандарт хэмжээнээс давсан үзүүлэлттэй мөн физик шинж чанарын хувьд шар өнгөтэй, тунадастай ус байна.

ХҮСНЭГТ 4. УСАН ОРЧНЫ ХҮНД МЕТАЛЛЫН ШИНЖИЛГЭЭ

№	Дээжийн дугаар	Хүнд металлын агууламж								
		Элемент мг/л								
		Ag	Al	As	B	Ba	Cd	Cr	Cu	Fe
1	Цайн хужирын булаг	<0.004	<0.01	<0.01	0.3	0.03	<0.01	<0.01	<0.01	<0.01
2	Үертийн булаг	<0.004	<0.01	<0.01	0.5	0.02	<0.01	<0.01	<0.01	<0.01
3	Салаа булаг	0.005	<0.01	<0.01	0.6	0.02	<0.01	<0.01	<0.01	<0.01
4	Хадны булаг	<0.004	0.07	0.01	0.1	0.01	<0.01	<0.01	0.07	0.20
5	Хадны булаг-2	<0.004	<0.01	<0.01	0.3	0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01
6	Сэртэнгийн булаг	<0.004	0.02	0.06	0.1	0.02	<0.01	<0.01	<0.01	<0.01
7	Цагаан хонхорын булаг	<0.004	0.07	0.04	0.1	0.01	<0.01	0.01	<0.01	<0.01
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ		0.1	0.5	0.01	1	2	0.003	0.005	1.0	0.3

MNS 6148:2010										
Дээжийн дугаар		Элемент мг/л								
		Hg	Mn	Mo	Ni	Pb	Sb	V	Zn	
1	Цайн хужирын булаг	<0.02	<0.01	0.02	0.02	<0.02	<0.04	<0.01	<0.01	
2	Үертийн булаг	<0.02	<0.01	<0.01	0.01	<0.02	<0.04	<0.01	<0.01	
3	Салаа булаг	<0.02	<0.01	<0.01	0.01	<0.02	<0.04	<0.01	<0.01	
4	Хадны булаг	<0.02	0.01	<0.01	0.03	0.02	<0.04	<0.01	0.10	
5	Хадны булаг-2	0.02	<0.01	<0.01	0.01	<0.02	<0.04	<0.01	<0.01	
6	Сэртэнгийн булаг	<0.02	<0.01	0.01	0.01	<0.02	<0.04	<0.01	<0.01	
7	Цагаан хонхорын булаг	<0.02	<0.01	<0.01	0.01	0.05	0.07	<0.01	<0.01	
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010		0.002	0.1	0.04	0.1	0.05	0.006	0.06	5.0	

Уст цэгүүдийн дээжийн хүнд металлын шинжилгээг “Алс” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид тодорхойлуулсан ба Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:2024, Усны чанар Газрын доорх бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010 стандартуудтай харьцуулахад Богд-IV талбайн Сэртэнгийн булаг, Цагаан хонхорын булгийн Хүнцэл (As)-ийн агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их бусад үзүүлэлтүүд хэвийн байв. Иймд орчны хяналт шинжилгээ мониторингийн хүрээнд тухайн цэгүүдээс дээж авч усны ерөнхий шинжилгээ, хүнд металлын шинжилгээг тогтмол хийлгэж хянаж байх нь зүйтэй.

5.4 АГААРЫН ЧАНАРЫН ХЭМЖИЛТ

Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын талбайн орчмын хүхэрлэг хий, азотын давхар исэл, PM 2.5, PM 1.0, PM 10 тоосонцорын хэмжээ “Агаарын чанарын MNS4585:2016 стандарт болон Европын холбооны орчны агаарын чанарын стандартын жилд зөвшөөрөгдөх тоон хэмжээнээс давсан үзүүлэлтгүй байна. Төслийн талбай орчмын дуу чимээний хэмжилтийг ОУСК болон Монгол улсын стандартад заасан утгуудтай харьцуулахад орчны хяналт шинжилгээний мониторингийн цэгүүд дээр стандарт хэмжээнээс давсан үзүүлэлтгүй байна.

ХҮСНЭГТ 5. ТӨСЛИЙН ТАЛБАЙН АГААРЫН ХЭМЖИЛТ

Цэгийн нэр	O_2 – Хүчилтөрөгч	EX- Шатамхай хий	H_2S- Хүхэрт устөрөгч	CO- Нүүрстөрөгчийн дутуу исэл
DL23-03D-01 (2025) 46^{0}12’1”/97^{0}17’20”	20.3%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL24-01D-01 (2025) 46^{0}10’33”/97^{0}15’56”	20.2%VOL **NORMAL**	0%LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL24-02D 46^{0}12’56”/97^{0}15’19”	20.9%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL24-03D 46^{0}10’9”/97^{0}21’25”	20.9%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL24-04 46^{0}13’25”/97^{0}20’7”	20.9%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
Camp-2024 46^{0}11’35”/97^{0}17’3”	20.4%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**

DL25-01D-01 46⁰14’33”/97⁰16’3”	20.2%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL25-01D-02 46⁰14’35”/97⁰14’40”	20.1%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL25-03 46⁰12’56”/97⁰14’15”	20.9%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL25-04 46⁰14’5”/97⁰15’18”	20.3%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**

Тахь ресурс” ХХК-ийн Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Богд-IV төслийн Дэлгэр хайгуулын талбай орчим O_2 Хүчилтөрөгчийн хэмжээ хэвийн EX- Шатамхай хий, H_2S- Хүхэрт устөрөгч болон CO- Нүүрстөрөгчийн дутуу исэл илрээгүй хэвийн байна.

Төслийн талбайн агаарын болон ургамалан нөмрөгийн сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор туслан гүйцэтгэгч компанид ашиглагдах тээврийн хэрэгсэлүүд үзлэг оношилгоонд орсны дараа ажилд гаргасан. Тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоог тогтмол хийж, хөдөлгүүрээс гарах хорт хийн ялгарлыг орчны хяналт шинжилгээний хүрээнд хэмжилт хийсэн. Нэг замын бодлого баримтлаж ажилласан. Тээврийн хэрэгслээс болоод хуурайшилттай үед замын усалгааг хийж байсан.

ЗУРАГ.10 ТООСЖИЛТТОЙ ҮЕД ЗАМЫН УСАЛГАГА ХИЙЖ БУЙ БАЙДАЛ

5.5 УРГАМЛАН НӨМРӨГ

Ургамлан нөмрөгийн мониторингийн судалгаагаар Дэлгэр талбайн дийлэнх хэсэг хуурай хээрийн бүсэд хамаарах бөгөөд *(i) Хялгана-ерхөгт, (ii) Харгана-шарилж оролцсон хялгана-хазаар өвст, (iii) Хялгана-таанат*, *(iv) Хялгана-таана-баглуурт, (v) Ерхөг-хялгана-алаг өвст, (v) Ерхөг-хялгана-алаг өвст, (vi) Шарилж-хунчир оролцсон ерхөг-хялгана-алаг өвст* бүлгэмдлүүд тархсан. 2023 оны Дэлгэр талбай орчмын судалгааны дүнгээс 8 зүйл, 2024 оны ургамалжлын мониторинг судалгаанд нийт 7 овгийн 11 төрлийн 13 зүйл, 2025 оны ургамалжлын мониторинг судалгаанд нийт 6 овгийн 9 төрлийн 9 зүйл бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 6. ТЭМДЭГЛЭГДСЭН УРГАМЛЫН ЗҮЙЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Түгээмэл нэр	Тэмдэглэгдсэн он			Шинжлэх ухааны нэр	Аж ахуйн бүлэг
1	Ширэг өлөн		*2024*	*2025*	*Carex duriuscula*	Улалж
2	Амманы сэдэргэнэ	*2023*	*2024*		*Convolvulus ammannii*	Алаг өвс
3	Саман ерхөг		*2024*	*2025*	*Agropyron cristatum*	Үетэн
4	Үндсэрхэг сонгино	*2023*	*2024*	*2025*	*Allium polyrhizum*	Алаг өвс
5	Гялгар дэрс		*2024*	*2025*	*Neotrinia splendens*	Үетэн
6	Адамсын шарилж		*2024*	*2025*	*Artemisia adamsii*	Алаг өвс
7	Сантолин навчит шарилж		*2024*		*Artemisia santolinifolia*	Алаг өвс
8	Сайрын хялгана	*2023*	*2024*	*2025*	*Stipa caucasica* subsp. *glareosa*	Үетэн
9	Крыловын хялгана		*2024*	*2025*	*Stipa krylovii*	Үетэн
10	Дэлгээ мананхамхаг	*2023*	*2024*		*Bassia prostrata*	Алаг өвс
11	Ахар навчит баглуур	*2023*	*2024*	*2025*	*Anabasis brevifolia*	Сөөг
12	Орог тэсэг		*2024*		*Kraschnikovia ceratoides*	Сөөг
13	Үхэр шүлхэй		*2024*	*2025*	*Neopallasia pectinata*	Цөөн наст

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Баянбуурал багийн нутагт орчих Бүтээгдэхүүн хуваах гэрээт Богд-IV блокийн Дэлгэр сумын нарийвчилсан хайгуулын талбайд 2025 оны хайгуулын батлагдсан төлөвлөгөөний дагуу цооногуудын өрөмдлөгийн ажлыг 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс эхлүүлэн 70 орчим хоногийн хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн. Хайгуулын үйл ажиллагааны явагдах үед талбайд өрөмдлөгийн шингэний хаягдлын сан, ахуйн хаягдалын талбай, суваг шуудуу зэрэг нийт 0,1640 га талбай хөндөгдсөн. Хөндөгдсөн талбайн техникийн нөхөн сэргээлтийг өрөмдлөгийн ажлыг туслан гүйцэтгэгч компани хийж гүйцэтгэсэн.

Хөрсөнд бохирдол үүсэхээс сэргийлж, цооногийн угаалгад ашиглах техникийн ус болон өрөмдлөгийн шингэний хаягдалыг хадгалах зориулалтаар бэлтгэсэн санд пластик уутыг дэвсэж, өрөмдлөг дууссаны дараагаар пластик уутыг авч нөхөн сэргээлтийг хийсэн.

Хаягдлын санг нөхөн сэргээхдээ түүний доторх орчин хатаж, хаягдалын сангийн доторх тал тогтвортой хатуу төлөв байдалтай болсон нөхцөлд нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Хаягдлын сангийн дүүргэлтийг хийхдээ хурдас чулуулаг, хөрс шороог асгаж тэгшилсэн. Үүний дараа хаягдалын сангийн нөхөн сэргээлт хийсэн талбайд хөрсийг 0,07МПа (1м2 талбайд 7тн жингээр дарах хүч)-аас багагүй даралтыг даах хэмжээнд хүртэл нягтруулах аргаар хийсэн. Ийнхүү хаягдлын санг дарж булсны дараагаар шимт хөрсөөр хучиж, тэгшилсэн байна.

Цооногуудын техникийн нөхөн сэргээлтийг Техникийн ерөнхий шаардлага “MNS 6200:2010” стандартын дагуу туслан гүйцэтгэгч компаний бүрэн хийж гүйцэтгэн Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Засаг даргаар ахлуулсан ажлын комисст нөхөн сэргээлт хийсэн үр дүнтэй 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр газар дээр нь танилцаж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/439 тоот тушаалын Нэгдүгээр хавсралтын дагуу “Тусгай зөвшөөрөлтэй талбайд нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээн авах акт” үйлдэн тухайн сумаас байгуулагдсан ажлын комисст тухайн өдрөө хүлээлгэн өгсөн.

		0,01 буюу суурь түвшин	0,06	0,12	0,3	>0,3	0.50	0.01	0.1	Mg^{++}	48.0	3.95	38.1
Нитрат	NO_3^-	I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %	Катион	Мг	Мг-экв	Мг-экв %
		1 буюу суурь түвшин	3	6	10	>10	18.0	0.29	2.8	NH_4^+	0.0	0.00	0.0
Карбонат	CO_3^{--}	-	-	-	-	-	0.0	0.00	0.0	Fe^{++}	0.0	0.00	0.0
Гидрокарбонат	HCO_3^-	-	-	-	-	-	396.5	6.50	62.6	Fe^{+++}	0.1	0.01	0.1
Дүн		-	-	-	-	-	571.9	10.38	100.0	Дүн	182.6	10.38	100.0

Шинжилсэн үзүүлэлт	**Нэгж**	**Зөвшөөрөгдөх дээд хэмжээ**	**Салаа булаг**
Ерөнхий хатуулаг	Мг-экв/дм^3	7.0	08.41
Урвалын орчин	pH	6.5-8.5	6.85
ЦДЧ (EC)	dS/m	-	916
Үнэр	Оноо	<2.0	Үгүй
Өнгө	Градус	<20.0	Өнгөгүй
Амт	Оноо	<2.0	***
Тунгалаг	см	-	>30
Тунадас	-	-	Үгүй
HCO_3-ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр	мг/дм^3	-	556.3
Анион катионуудын нийлбэр 745 мг/дм^3	мг/дм^3	-	754.5
Булингаршил	NTU	I зэрэг <5 болон суурь түвшин	4.14

Дүгнэлт: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн магнийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатуу ус байна. Шинжилсэн үндсэн үзүүлэлтүүдээс нитритийн азотын агууламж нь “Усны орчны чанар. Ерөнхий шаардлага MNS 4586:2024 стандартад зааснаас их байна.

ХАДНЫ БУЛАГ (DL25-04US)

ЗУРАГ 20. ХАДНЫ БУЛАГ

Нэршил	Анион	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ					1 дм3-д байгаа			Катион	1 дм3-д байгаа		
		I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %		Мг	Мг-экв	Мг-экв %
Хлорид	Cl^-	200 буюу суурь түвшин	200	350	500	>500	34.4	0.97	9.7	Na^+K^+	61.7	2.68	26.8
Сульфат	SO_4^{--}	I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %	Катион	Мг	Мг-экв	Мг-экв %
		<60 буюу суурь түвшин	100	200	400	>400	88.0	1.83	18.3	Ca^{++}	70.3	3.51	35.1
Нитрит	NO_2^-	I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %	Катион	Мг	Мг-экв	Мг-экв %
		0,01 буюу суурь түвшин	0,06	0,12	0,3	>0,3	0.00	0.00	0.0	Mg^{++}	45.6	3.75	37.5
Нитрат	NO_3^-	I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %	Катион	Мг	Мг-экв	Мг-экв %
		1 буюу суурь түвшин	3	6	10	>10	12.0	0.19	1.9	NH_4^+	0.0	0.00	0.0
Карбонат	CO_3^{--}	-	-	-	-	-	0.0	0.00	0.0	Fe^{++}	0.0	0.00	0.0
Гидрокарбонат	HCO_3^-	-	-	-	-	-	427.0	7.00	70.0	Fe^{+++}	1.0	0.05	0.5
Дүн		-	-	-	-	-	561.4	10.00	100.0	Дүн	178.7	10.00	100.0

Шинжилсэн үзүүлэлт	**Нэгж**	**Зөвшөөрөгдөх дээд хэмжээ**	**Хадны булаг**
Ерөнхий хатуулаг	Мг-экв/дм^3	7.0	7.26
Урвалын орчин	pH	6.5-8.5	7.13
ЦДЧ (EC)	dS/m	-	851
Үнэр	Оноо	<2.0	Үгүй
Өнгө	Градус	<20.0	Шар
Амт	Оноо	<2.0	***
Тунгалаг	см	-	8
Тунадас	-	-	Бага зэрэг
HCO_3-ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр	мг/дм^3	-	526.6
Анион катионуудын нийлбэр 745 мг/дм^3	мг/дм^3	-	740.1
Булингаршил	NTU	I зэрэг <5 болон суурь түвшин	109.0

Дүгнэлт: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, холимог бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатуу ус байна. Шинжилсэн үндсэн үзүүлэлтүүд нь “Усны орчны чанар. Ерөнхий шаардлага MNS 4586:2024 стандартын шаардлага хангаж байгаа боловч физик үзүүлэлтүүдийн хувьд шар өнгөтэй, тунадастай ус байна.

ХАДНЫ БУЛАГ-2 (DL25-05US)

ЗУРАГ 21. ХАДНЫ БУЛАГ-2

Нэршил	Анион	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ					1 дм3-д байгаа			Катион	1 дм3-д байгаа		
		I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %		Мг	Мг-экв	Мг-экв %
Хлорид	Cl^-	200 буюу суурь түвшин	200	350	500	>500	35.5	1.00	8.7	Na^+K^+	72.5	3.15	27.5
Сульфат	SO_4^{--}	I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %	Катион	Мг	Мг-экв	Мг-экв %
		<60 буюу суурь түвшин	100	200	400	>400	125.0	2.60	22.8	Ca^{++}	49.1	2.45	21.4
Нитрит	NO_2^-	I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %	Катион	Мг	Мг-экв	Мг-экв %
		0,01 буюу суурь түвшин	0,06	0,12	0,3	>0,3	0.45	0.01	0.1	Mg^{++}	70.5	5.80	50.7
Нитрат	NO_3^-	I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %	Катион	Мг	Мг-экв	Мг-экв %
		1 буюу суурь түвшин	3	6	10	>10	14.0	0.23	2.0	NH_4^+	0.7	0.04	0.3
Карбонат	CO_3^{--}	-	-	-	-	-	6.0	0.20	1.7	Fe^{++}	0.0	0.00	0.0
Гидрокарбонат	HCO_3^-	-	-	-	-	-	451.4	7.40	64.7	Fe^{+++}	0.0	0.00	0.0
Дүн		-	-	-	-	-	632.4	11.44	100.0	Дүн	192.8	11.44	100.0

Шинжилсэн үзүүлэлт	**Нэгж**	**Зөвшөөрөгдөх дээд хэмжээ**	**Хадны булаг-2**
Ерөнхий хатуулаг	Мг-экв/дм^3	7.0	8.25
Урвалын орчин	pH	6.5-8.5	7.78
ЦДЧ (EC)	dS/m	-	958
Үнэр	Оноо	<2.0	Үгүй
Өнгө	Градус	<20.0	Сул шаргал
Амт	Оноо	<2.0	***
Тунгалаг	см	-	28
Тунадас	-	-	Үл мэдэг
HCO_3-ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр	мг/дм^3	-	599.4
Анион катионуудын нийлбэр 745 мг/дм^3	мг/дм^3	-	825.1
Булингаршил	NTU	I зэрэг <5 болон суурь түвшин	1.81

Дүгнэлт: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, магнийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатуу ус байна. Шинжилсэн үндсэн үзүүлэлтүүдээс магни, нитритийн азотын агууламж нь “Усны орчны чанар. Ерөнхий шаардлага MNS 4586:2024 стандартад зааснаас их байна.

СЭРТЭНГИЙН БУЛАГ (DL25-06US)

ЗУРАГ 22. СЭРТЭНГИЙН БУЛАГ

Нэршил	Анион	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ					1 дм3-д байгаа			Катион	1 дм3-д байгаа		
		I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %		Мг	Мг-экв	Мг-экв %
Хлорид	Cl^-	200 буюу суурь түвшин	200	350	500	>500	35.5	1.00	11.3	Na^+K^+	55.2	2.40	27.2
Сульфат	SO_4^{--}	I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %	Катион	Мг	Мг-экв	Мг-экв %
		<60 буюу суурь түвшин	100	200	400	>400	110.0	2.29	26.0	Ca^{++}	62.7	3.13	35.5
Нитрит	NO_2^-	I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %	Катион	Мг	Мг-экв	Мг-экв %
		0,01 буюу суурь түвшин	0,06	0,12	0,3	>0,3	0.00	0.00	0.0	Mg^{++}	39.9	3.28	37.2
Нитрат	NO_3^-	I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %	Катион	Мг	Мг-экв	Мг-экв %
		1 буюу суурь түвшин	3	6	10	>10	14.0	0.23	2.6	NH_4^+	0.0	0.00	0.0
Карбонат	CO_3^{--}	-	-	-	-	-	0.0	0.00	0.0	Fe^{++}	0.0	0.00	0.0
Гидрокарбонат	HCO_3^-	-	-	-	-	-	323.3	5.30	60.1	Fe^{+++}	0.1	0.01	0.1
Дүн		-	-	-	-	-	482.8	8.82	100.0	Дүн	158.0	8.82	100.0

Шинжилсэн үзүүлэлт	**Нэгж**	**Зөвшөөрөгдөх дээд хэмжээ**	**Сэртэнгийн булаг**
Ерөнхий хатуулаг	Мг-экв/дм^3	7.0	6.41
Урвалын орчин	pH	6.5-8.5	7.26
ЦДЧ (EC)	dS/m	-	830
Үнэр	Оноо	<2.0	Үгүй
Өнгө	Градус	<20.0	Өнгөгүй
Амт	Оноо	<2.0	***
Тунгалаг	см	-	>30
Тунадас	-	-	Үгүй
HCO_3-ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр	мг/дм^3	-	479.1
Анион катионуудын нийлбэр 745 мг/дм^3	мг/дм^3	-	640.8
Булингаршил	NTU	I зэрэг <5 болон суурь түвшин	0.81

Дүгнэлт: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, холимог бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатуувтар ус байна. Шинжилсэн үндсэн үзүүлэлтүүд нь “Усны орчны чанар. Ерөнхий шаардлага MNS 4586:2024 стандартын шаардлага хангаж байна.

ЦАГААН ХОНХОРЫН БУЛАГ (DL25-07US)

ЗУРАГ 23. ЦАГААН ХОНХОРЫН БУЛАГ

Нэршил	Анион	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ					1 дм3-д байгаа			Катион	1 дм3-д байгаа		
		I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %		Мг	Мг-экв	Мг-экв %
Хлорид	Cl^-	200 буюу суурь түвшин	200	350	500	>500	90.5	2.55	21.3	Na^+K^+	95.8	4.16	34.7
Сульфат	SO_4^{--}	I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %	Катион	Мг	Мг-экв	Мг-экв %
		<60 буюу суурь түвшин	100	200	400	>400	210.0	4.38	36.5	Ca^{++}	42.7	2.13	17.8
Нитрит	NO_2^-	I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %	Катион	Мг	Мг-экв	Мг-экв %
		0,01 буюу суурь түвшин	0,06	0,12	0,3	>0,3	0.03	0.00	0.0	Mg^{++}	69.2	5.69	47.5
Нитрат	NO_3^-	I зэрэг	II зэрэг	III зэрэг***	IV зэрэг	V зэрэг	Мг	Мг-экв	Мг-экв %	Катион	Мг	Мг-экв	Мг-экв %
		1 буюу суурь түвшин	3	6	10	>10	16.0	0.26	2.2	NH_4^+	0.0	0.00	0.0
Карбонат	CO_3^{--}	-	-	-	-	-	0.0	0.00	0.0	Fe^{++}	0.0	0.00	0.0
Гидрокарбонат	HCO_3^-	-	-	-	-	-	292.8	4.80	40.1	Fe^{+++}	0.0	0.00	0.0
Дүн		-	-	-	-	-	609.4	11.98	100.0	Дүн	207.6	11.98	100.0

Шинжилсэн үзүүлэлт	**Нэгж**	**Зөвшөөрөгдөх дээд хэмжээ**	**Цагаан хонхорын булаг**
Ерөнхий хатуулаг	Мг-экв/дм^3	7.0	7.82
Урвалын орчин	pH	6.5-8.5	7.39
ЦДЧ (EC)	dS/m	-	1183
Үнэр	Оноо	<2.0	Үгүй
Өнгө	Градус	<20.0	Сул шаргал
Амт	Оноо	<2.0	***
Тунгалаг	см	-	22
Тунадас	-	-	Үл мэдэг
HCO_3-ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр	мг/дм^3	-	670.6
Анион катионуудын нийлбэр 745 мг/дм^3	мг/дм^3	-	817.0
Булингаршил	NTU	I зэрэг <5 болон суурь түвшин	10.7

Дүгнэлт: Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын-сульфатын ангийн, магнийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, хатуу ус байна. Шинжилсэн үндсэн үзүүлэлтүүдээс магни, сульфатын агууламж нь “Усны орчны чанар. Ерөнхий шаардлага MNS 4586:2024 стандартад зааснаас их, физик үзүүлэлтүүдийн хувьд сул шаргал өнгөтэй, тунадастай ус байна.

ХҮСНЭГТ 21. УСАН ОРЧНЫ МОНИТОРИНГИЙН ЦЭГҮҮД

№	Цэгийн нэр	Стандарт хэмжээ дэх нийцэл	Үзүүлэлт	Харьцуулалт
1	Цайн хужирын булаг	“Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:2024” Их	Магнийн ион	2025 оны шинэ мониторингийн цэг
2	Үертийн булаг	“Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:2024”	Стандартын шаардлага хангаж байна.	2024 оны үзүүлэлтээс өөрчлөгдсөн (Сульфат, нитритийн азотын агууламж ЗДХ болсон)
3	Салаа булаг	“Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:2024” Их	Нитритийн азот	2025 оны шинэ мониторингийн цэг
4	Хадны булаг	“Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:2024”	Физик үзүүлэлтүүдийн хувьд шар өнгөтэй, тунадастай ус	2025 оны шинэ мониторингийн цэг
5	Хадны булаг-2	“Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:2024” Их	Магни, нитритийн азот	2025 оны шинэ мониторингийн цэг
6	Сэртэнгийн булаг	“Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:2024”	Стандартын шаардлага хангаж байна.	2024 оны үзүүлэлтээс өөрчлөгдсөн (Сульфатын ион ЗДХ болсон)
7	Цагаан хонхорын булаг	“Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:2024” Их	Магни, сульфатын ион Физик үзүүлэлтүүдийн хувьд сул шаргал өнгөтэй тунадастай ус	2024 оны агууламжаас багассан

Усан орчны шинжилгээний дүнгээр ***Сэртэнгийн булаг*** 2024 онд Сульфатын ионы агууламж “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS4586:2024 стандартад зааснаас их буюу 155.0 мг байсан бөгөөд 2025 оны шинжилгээний дүнгээр стандарт хэмжээнд буюу 110.0 мг болсон байна.

Цагаан хонхорын булаг 2024 онд Сульфатын ион 350.0 мг байсан бол 2025 онд 210.0 мг болж багассан. Магнийн ион 89.7 мг байсан бол 2025 онд 69.2 мг болж багассан үзүүлэлттэй байна.

БОГД-IV ТАЛБАЙН УСАН ОРЧНЫ ХҮНД МЕТАЛЛЫН ШИНЖИЛГЭЭ

ХҮСНЭГТ 22. УСАН ОРЧНЫ ХҮНД МЕТАЛЛЫН ШИНЖИЛГЭЭ

№	Дээжийн дугаар	Хүнд металлын агууламж								
		Элемент мг/л								
		Ag	Al	As	B	Ba	Cd	Cr	Cu	Fe
1	Цайн хужирын булаг	<0.004	<0.01	<0.01	0.3	0.03	<0.01	<0.01	<0.01	<0.01
2	Үертийн булаг	<0.004	<0.01	<0.01	0.5	0.02	<0.01	<0.01	<0.01	<0.01
3	Салаа булаг	0.005	<0.01	<0.01	0.6	0.02	<0.01	<0.01	<0.01	<0.01
4	Хадны булаг	<0.004	0.07	0.01	0.1	0.01	<0.01	<0.01	0.07	0.20
5	Хадны булаг-2	<0.004	<0.01	<0.01	0.3	0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01
6	Сэртэнгийн булаг	<0.004	0.02	0.06	0.1	0.02	<0.01	<0.01	<0.01	<0.01
7	Цагаан хонхорын булаг	<0.004	0.07	0.04	0.1	0.01	<0.01	0.01	<0.01	<0.01
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010		0.1	0.5	0.01	1	2	0.003	0.005	1.0	0.3
Дээжийн дугаар		Элемент мг/л								
		Hg	Mn	Mo	Ni	Pb	Sb	V	Zn	
1	Цайн хужирын булаг	<0.02	<0.01	0.02	0.02	<0.02	<0.04	<0.01	<0.01	
2	Үертийн булаг	<0.02	<0.01	<0.01	0.01	<0.02	<0.04	<0.01	<0.01	
3	Салаа булаг	<0.02	<0.01	<0.01	0.01	<0.02	<0.04	<0.01	<0.01	
4	Хадны булаг	<0.02	0.01	<0.01	0.03	0.02	<0.04	<0.01	0.10	
5	Хадны булаг-2	0.02	<0.01	<0.01	0.01	<0.02	<0.04	<0.01	<0.01	
6	Сэртэнгийн булаг	<0.02	<0.01	0.01	0.01	<0.02	<0.04	<0.01	<0.01	
7	Цагаан хонхорын булаг	<0.02	<0.01	<0.01	0.01	0.05	0.07	<0.01	<0.01	
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010		0.002	0.1	0.04	0.1	0.05	0.006	0.06	5.0	

Уст цэгүүдийн дээжийн хүнд металлын шинжилгээг “Алс” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид тодорхойлуулсан ба Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS 4586:2024, Усны чанар Газрын доорх бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010 стандартуудтай харьцуулахад Богд-IV талбайн Сэртэнгийн булаг, Цагаан хонхорын булгийн Хүнцэл (As)-ийн агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их бусад үзүүлэлтүүд хэвийн байв. Иймд орчны хяналт шинжилгээ мониторингийн хүрээнд тухайн цэгүүдээс дээж авч усны ерөнхий шинжилгээ, хүнд металлын шинжилгээг тогтмол хийлгэж хянаж байх нь зүйтэй.

13.3 Агаарын чанарын мониторингийн судалгаа:

“Тахь Ресурс” ХХК-ийн Говь-Алтай аймаг дахь Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Богд-IV талбайн 2025 оны орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд 10 цэгт агаарын чанарын өнөөгийн байдлыг тодорхойлох зорилгоор агаар дахь бохирдуулагч бодисуудыг агууламжын хэмжилт судалгааны мэдээллийг үндэслэн тооцсон. Агаарын чанарыг 2025 оны 09 сарын 23-24 өдөр хэмжилтийг хийж Монгол улсын хэмжээнд агаарын чанарыг MNS 4585:2016 стандарттай болон Европын холбооны орчны агаарын чанарын стандартын жилд зөвшөөрөгдөх тоон хэмжээтэй харьцууллаа.

ЗУРАГ 24. ТӨСЛИЙН ТАЛБАЙН АГААРЫН ЧАНАРЫН МОНИТОРИНГИЙН СУДАЛГААНЫ ЦЭГҮҮД

Цэгийн нэр	O_2 – Хүчилтөрөгч	EX- Шатамхай хий	H_2S- Хүхэрт устөрөгч	CO- Нүүрстөрөгчийн дутуу исэл
DL23-03D-01 (2025) 46^{0}12’1”/97^{0}17’20”	20.3%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL24-01D-01 (2025) 46^{0}10’33”/97^{0}15’56”	20.2%VOL **NORMAL**	0%LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL24-02D 46^{0}12’56”/97^{0}15’19”	20.9%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL24-03D 46^{0}10’9”/97^{0}21’25”	20.9%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL24-04 46^{0}13’25”/97^{0}20’7”	20.9%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
Camp-2024 46^{0}11’35”/97^{0}17’3”	20.4%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL25-01D-01 46^{0}14’33”/97^{0}16’3”	20.2%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL25-01D-02 46^{0}14’35”/97^{0}14’40”	20.1%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL25-03 46^{0}12’56”/97^{0}14’15”	20.9%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**
DL25-04 46^{0}14’5”/97^{0}15’18”	20.3%VOL **NORMAL**	0 %LEL **LOW**	0 PPM **LOW**	0 PPM **LOW**

Тахь ресурс” ХХК-ийн Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Богд-IV төслийн Дэлгэр хайгуулын талбай орчим O_2 Хүчилтөрөгчийн хэмжээ хэвийн EX- Шатамхай хий, H_2S- Хүхэрт устөрөгч болон CO- Нүүрстөрөгчийн дутуу исэл илрээгүй хэвийн байна.

ЗУРАГ 25. ХИЙН ХЭМЖИЛТ ХИЙЖ БУЙ БАЙДАЛ	ЗУРАГ 26. ДУУ ЧИМЭЭЭНИЙ ХЭМЖИЛТ ХИЙЖ БУЙ БАЙДАЛ	ЗУРАГ 27. ТООСНЫ ХЭМЖИЛТ ХИЙЖ БУЙ БАЙДАЛ

ХҮСНЭГТ 24. ТӨСЛИЙН ТАЛБАЙН АГААРЫН ХЭМЖИЛТ

Цэгийн нэр	PM 2.5 мкг/м^3	PM 1.0 мкг/м^3	PM 10 мкг/м^3	TVOC мг/м^3	AQI	Температур ^{0}C	Чийгшил %
DL23-03D-01 (2025) 46^{0}12’1”/97^{0}17’20”	8	4	10	0.000	Very good	24.9	13
DL24-01D-01 (2025) 46^{0}10’33”/97^{0}15’56”	6	3	7	0.550	Very good	14.5	37
DL24-02D 46^{0}12’56”/97^{0}15’19”	8	4	10	0.000	Very good	22.1	15
DL24-03D 46^{0}10’9”/97^{0}21’25”	9	5	11	0.720	Very good	24.0	23
DL24-04 46^{0}13’25”/97^{0}20’7”	15	9	20	0.210	Very good	24.9	22
Camp-2024 46^{0}11’35”/97^{0}17’3”	8	4	10	0.057	Very good	19.5	23
DL25-01D-01 46^{0}14’33”/97^{0}16’3”	8	8	10	0.009	Very good	14.8	32
DL25-01D-02 46^{0}14’35”/97^{0}14’40”	9	5	11	0.272	Very good	15.2	33

DL25-03 $46^0$12’56”/$97^0$14’15”	8	4	10	0.006	Very good	12.1	43
DL25-04 $46^0$14’5”/$97^0$15’18”	0	0	00	0.006	Very good	17.0	32

Монгол улсын хэмжээнд агаарын чанарыг MNS 4585:2016 стандартын дагуу мөрддөг бөгөөд энэ стандартаар:

ХҮСНЭГТ 25. АГААР ДАХЬ ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ БОХИРДУУЛАХ БОДИСЫН ХҮЛЦЭХ АГУУЛАМЖ БОЛОН ФИЗИКИЙН СӨРӨГ НӨОӨЛЛИЙН ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ

Үзүүлэлтийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Хүлцэх агууламж
Химийн нөлөөлөл			
Хүхэрлэг хий (SO_2)	20 минутын дундаж 24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м^3	450 50 20
Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)	20 минутын дундаж 1 цагийн дундаж 8 цагийн дундаж	мкг/м^3	60000 30000 10000
Азотын давхар исэл (NO_2)	20 минутын дундаж 24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м^3	200 50 40
Озон (O_3)	8 цагийн дундаж	мкг/м^3	100
Нийт тоосонцор	20 минутын дундаж 24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м^3	500 150 100
PM 10 тоосонцор	24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м^3	100 50
PM 2.5 тоосонцор	24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м^3	50 25
Хар тугалга (Pb)	24 цагийн дундаж Жилийн дундаж	мкг/м^3	1 0.25
Бенз-а-пирен ($C_{20}H_{12}$)	24 цагийн дундаж	мкг/м^3	0.001
Физикийн нөлөөлөл			
Үзүүлэлтүүдийн нэр	Хэмжилтийн дундаж хугацаа	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Дуу шуугиан -Өдрийн цаг (07-22) Шөнийн цаг (22-07)	16 цагийн дундаж 8 цагийн дундаж	дБА	60 45

Энэхүү стандартын хамрах хүрээ нь хот суурин газруудад хамаарагдах тул орон нутаг дахь байгууламжид ашиглахад учир дутагдалтай бөгөөд ОУСК (Олон улсын

санхүүгийн корпораци)-ын удирдамжид олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг ашиглах шаардлагатай гэж зөвлөжээ. ОУСК-ын ерөнхий удирдамжид дурдсанаар Европын холбооны орчны агаарын чанарын стандарт[5]-ыг тайланд тусган үзлээ.

ХҮСНЭГТ 26. ЕВРОПЫН ХОЛБООНЫ ОРЧНЫ АГААРЫН ЧАНАРЫН СТАНДАРТ

Үзүүлэлт	Дундаж хугацаа	ЕХ-ын Орчны агаарын чанарын стандарт (мг/м^3)	Жилд зөвшөөрөгдөх тоон хэмжээ
Хүхрийн давхар исэл (SO_2)	1 цаг 24 цаг	350 125	24 3
Угаарын хий (CO)	8 цаг	10,000	байхгүй
Азотын давхар исэл (NO_2)	1 цаг Жил	200 40	18 байхгүй
Озон (O_3)	8 цаг	120	25
PM10	24 цаг Жил	50 40	35 байхгүй
PM 2.5	Жил	25	Байхгүй
Хар тугалга	жил	0.5	Байхгүй
Бензоапирен	жил	0.001	Байхгүй

Төслийн талбай орчмын хүхэрлэг хий, азотын давхар ислийн хэмжээ, нийт тоосны хэмжээ“Агаарын чанарын MNS 4585:2016 стандарт” болон Европын холбооны орчны агаарын чанарын стандартын жилд зөвшөөрөгдөх тоон хэмжээнээс давсан үзүүлэлтгүй байна.

Монгол Улсын Дуу чимээ ба чичиргээний стандарт

Монгол Улсын Агаарын чанарын тухай стандарт MNS 4585:2007- ийн Техникийн ерөнхий шаардлагад заасны дагуу байгаль орчинд үүсэх дуу чимээний хамгийн их хэмжээ өдрийн цагаар 60 дБ(А), шөнийн цагт 45 дБ(А) тус тус байх ёстой.

Дуу чимээ ба чичиргээний олон улсын жишиг стандарт ба зөвлөмж

Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК):

Хүлээн авагчийн төрлөөс хамааран өдөр, шөнийн цагаар үүсэх дуу чимээний хэмжээг тогтоох зорилгоор ОУСК- аас дуу чимээний удирдамж гаргасан[6]. Энэхүү удирдамжийн дагуу дуу чимээний түвшинг доор заагдсан түвшнээс бага байлгах эсвэл хамгийн ихдээ 3 дБ-аас хэтрэхгүй байх шаардлагатай гэж заасан байна.

[5] *2008 оны 5- р сарын 21- ний Европын парламент болон зөвлөлөөс батлагдсан орчны агаарын чанар болон Европт цэвэр агаар буюу 2008/50/ЕС зөвлөмжөөс авсан ЕХ- ны агаарын чанарын шаардлагууд*

[6] *ОУСК-2007 оны 04 сарын 30 , Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны ерөнхий зөвлөмж*

Төслийн талбай орчмын дуу чимээний хэмжилтийг ОУСК болон Монгол улсын стандартад заасан утгуудтай харьцуулсан. Уг харьцуулалтаар хяналт шинжилгээний цэгүүд бүгд стандарт хэмжээд байна.

ХҮСНЭГТ 27. ДЭЛГЭР ХАЙГУУЛЫН ТАЛБАЙН ДУУ ЧИМЭЭНИЙ ХЭМЖИЛТ

Цэгийн дугаар	Дуу чимээний хэмжилтийн үр дүн	ОУСК-ын зааварчилгаа: Аж үйлдвэрийн/худалдааны	ОУСК-ийн зааварчилгаа: Иргэний/байгуулламжийн боловсролын	MNS 4585:2016
DL23-03D-01 (2025) $46^0$12’1”/$97^0$17’20”	32.2	70	55	60
DL24-01D-01 (2025) $46^0$10’33”/$97^0$15’56”	36.1			
DL24-02D $46^0$12’56”/$97^0$15’19”	36.1			
DL24-03D $46^0$10’9”/$97^0$21’25”	40.8			
DL24-04 $46^0$13’25”/$97^0$20’7”	31.5			
Camp-2024 $46^0$11’35”/$97^0$17’3”	30.2			
DL25-01D-01 $46^0$14’33”/$97^0$16’3”	35.0			
DL25-01D-02 $46^0$14’35”/$97^0$14’40”	36.1			
DL25-03 $46^0$12’56”/$97^0$14’15”	31.5			
DL25-04 $46^0$14’5”/$97^0$15’18”	39.6			

13.4 Амьтны аймгийн мониторингийн судалгаа:

Амьтны аймаг тодорхойлох арга зүй

Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын нутагт “Тахь ресурс” ХХК-ийн нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Богд-IV талбайн амьтны аймгийн мониторинг судалгааг “Их Зос” ХХК-ийн мэргэжилтнүүд хийж гүйцэтгэсэн. Судалгааны талбайд өмнө жилийн хайгуулын цооног гүйцэтгэсэн төлөвтэй байна.

Бид суурин ажиглалт болон явган замналын аргаар ажиглалт хийсэн бөгөөд тухайн үед ажиглагдсан шувууд болон мэрэгч, амьтдын баас, үүр ноохой, амьтны хөдөлгөөн ажиглаж тэмдэглэл үйлдэн хүснэгт боловсруулан фото зургаар баталгаажуулав.

Судалгааны багаж хэрэгсэл

Бид судалгаандаа хоёр нүдний дуран, хөдөлгөөн мэдрэгч камер, луужин амьтны зүйлийг тэмдэглэх хүснэгт ашиглав.

Судалгааны үр дүн

Монгол орны нутаг дэвсгэр байгаль газарзүйн хувьд нэн өвөрмөц онцлогтой учир бүс бүслүүр үүсгэж үүнд зохицож амьдрах амьтны аймаг нь ихээхэн баялаг бүрэлдэхүүнтэй. Өндөр уулын тагийн бүслүүрээс авахуулаад цөлийн бүс хүртэл бүх л бүс бүслүүрийн амьтад амьдрах нөхцөл бүрджээ. Говь цөлийн ландшафтад нутгийн уугуул буюу Төв азийн унаган амьтад олноор амьдарна.

Амьтны аймгийн бүрэлдэхүүнд хөхтөн, жигүүртэн, шавьж, хэвлээр явагчид, усны амьтад зонхилох бөгөөд нутгийн хойд хэсгийн уулархаг нутгийн ой тайгад амьдардаг хөхтөн амьтдаас атаахай, оготно, олон зүйлийн туурайтан, мах идэштэн байна. Ойт хээрийн бүсийн хээрт нүх үүр малтан орогнодог өвсөн тэжээлт тарвага, бусад жижиг амьтад зонхилсон хөхтөний бүлгэмдэл, харин хээрийн бүсийн зүүн захаар цагаан зээрийн сүрэг тархана. Цөлөрхөг хээрийн ба цөлийн бүсэд монгол чичүүл, зарим зүйл алагдаахай, шишнүүхэй үүнээс урагшлахад шар чичүүл зонхилно.

ЗУРАГ 28. МОНГОЛ ОРНЫ ЗООГЕОГРАФИЙН МУЖЛАЛ

Манай орны хойд ба өмнөд хэсгийн байгалийн нөхцөл, дулаан, хүйтэн, чийг, усан хангамж зэргийн ялгаанаас үүдэн амьтдын төрөл зүйл өөр өөр байдаг. Ан агнуурын хуулийн заалт ёсоор амьтныг:

Нэн ховор: амьтдад тахь, хавтгай, мазаалай, хар мөрний хандгай, цаа буга, хүдэр, минж, халиу, ирвэс, бөхөн, жороо тоодог, гургуул, гангар хун, цэн тогоруу, хар тогоруу, цагаан тогоруу, хилэм загас зэрэг 18 зүйлийн амьтад хамаарна.

Ховор амьтдад хөхтөнөөс аргаль, янгир, хулан, хар сүүлтий, халиун буга, ойн булга, зэгсийн гахай, говийн шилүүс, хадны суусар, цоохондой, эрээн хүрэн, гозоорой зурам,

шувуудаас алтайн хойлог, манхин галуу, хээрийн галуу, хошуу галуу, хуруут хун, гангар хун, байгалийн нугас, ухаа шумбуур, халзан ангир, ямаан сүүлт, цасч дэглий зэрэг 22 шувуу, цагаан амар, давх зэрэг загасны зүйл хамаарна[7].

Төслийн талбайн нутаг дэвсгэр нь 1954 онд ландшафтын мужлал, амьтны аймгийн чанарын болон тоон харьцаа гэсэн гурван зарчмыг баримтлан Банниковын гаргасан мужлалтаар Говь-Алтайн тойрогт хамаарагдана. [8]

Говь-Алтай аймагт Тахь, Хулан, Хавтгай, Аргаль, Янгир, Бөхөн, Хар сүүлтий, Буга зэрэг 8 зүйлийн гөрөөс, Мазаалай, Ирвэс, Булга, Суусар, Халиу зэрэг хөхтөн, Хун, Гургуул, Хотон, Хойлог, Ёл, Тас, Сар, Ууль, Бигбаатар, Шар шувуу, Тоншуул зэрэг шувууд тархана. Мөлхөгчдөөс хонин гүрвэл, могой, замба гүрвэл, тэмээн сүүлт могой Алтайн өвөр говьд оршдог.

Алтайн хойлог, цагаан ахууна, ятуу, хахилаг, ёл, тас зэргээс гадна говь хээрийн бүсийн шувуудын гол бүрдэл болох монгол болжмор, талын бүргэд тэрчлэн говь цөлийн бүсийн тоодог, хулан жороо, чогчого, зэржгэнэ мэтийг нэрлэж болно.

Монголын улаан номонд орсон Хавтгай, Хулан, Тахь, Аргаль, Янгир, Мазаалай, Бөхөн, Хар сүүлтий, Ирвэс зэрэг ховор амьтад байна.

Төслийн талбайг нийт 2 хэсэгт хуваж хоёр нүдний дуран болон телескопоор ажиглалт хийж судалгааны цэг бүрт байх амьтны баас, үүр ноохой, амьтны хөдөлгөөн буй эсэхийг ажиглаж тэмдэглэл үйлдсэн болно.

Хээрийн судалгааны явцад хөхтөн амьтад ажиглагдаагүй. Мөн дүрсийг нь буулгаж чадаагүй, холын зайнаас зүйлийг тодорхойлох боломжгүй шувууд болон мэрэгч зүйлүүд нэлээдгүй байсан юм. Иймд төслийн талбай орчимд тархаж болзошгүй амьдын дэлгэрэнгүй мэдээллийг доорх хэсэгт үзүүлэв.

Хөхтөн

Манай орны нутаг дэвсгэр дээр 128 зүйл уугуул хөхтөн тархан амьдардаг. Эндээс талбай орчимд 25 орчим зүйл тохиолдож болзошгүй юм. Бүс нутгийн хэмжээнд үнэлснээр “устаж болзошгүй -EN” 3 зүйл буюу Аргаль хонь, Цоохор ирвэс, Монгол тарвага, Эмзэг-1 зүйл буюу хар сүүлтий, “ховордож болзошгүй-NT”-6 зүйл буюу Янгир ямаа, Мануул мий, Шилүүс мий, Хярс, Үнэг, Саарал чоно тус тус байна[9].

[7] *Монголын байгалийн газарзүй*
[8] *Банников, 1954*
[9] *Монгол Улсын Хөхтөн амьтдын улаан данс УБ 2006*

ХҮСНЭГТ 28. ТӨСЛИЙН ТАЛБАЙД ТОХИОЛДОЖ БОЛЗОШГҮЙ АМЬТДЫН ЖАГСААЛТ

№	Монгол нэр	Шинжлэх ухааны нэр	Олон улсын үнэлгээ	Бүс нутгийн үнэлгээ	Улаан ном
1	Хар сүүлтий	*Gazella subgutturosa*	VU	VU	Ховор
2	Аргаль хонь	*Ovis ammon*	VU	EN	Ховор
3	Янгир ямаа	Capra sibirica	VU	NT	Ховор
Махан идэшт хөхтөн					
4	Хярс	*Vulpes corsac*	LC	EN	
5	Саарал чоно	*Canis lupus*	LC	NT	
6	Үнэг	*Vulpes vulpes*	LC	NT	
7	Мануул	*Felis manul*	NT	NT	
8	Цагаан үен	*Mustela erminea*	LC	LC	
9	Эрээн хүрнэ	*Vormela peregusna*	DD	LC	
10	Хадны суусар	Martes foina	LC	DD	Ховор
11	Цоохор ирвэс	Uncia uncia	NT	EN	Нэн ховор
12	Шилүүс мий	*Lynx lynx*	NT	NT	Ховор
Гар далавчтан					
13	Дэлдэн зараа	*Hemiechinus auratus*	LC	LC	Улаан данс
14	Саарал соотон багваахай	Plecotus kozlovii		DD	
15	Бор турсаахай	Hypsugo alaschanicus	LC	DD	
Мэрэгч					
16	Гэрийн хулгана	*Mus musculus*			
17	Үлийн цагаан оготно	*Lasiopodomys brandti*	LC	LC	
18	Монгол тарвага	*Marmota sibirica*	LC	EN	
19	Бор туулай	*Lepus tolai*		LC	
20	Урт сүүлт зурам	*Spermophilus undulatus*	LC	LC	
21	Орог зусаг	*Phodopus campbelli*	LC	LC	
22	Морин чичүүл	*Phombomys opimus*	LC	LC	
23	Шар чичүүл	*Meriones meridianus*	LC	LC	
24	Сибир алагдаага	*Allactaga sibirica*	LC	LC	
25	Зүлгийн оготно	*Microtus limnophilus*	LC	DD	
26	Говь Алтайн барагчин		DD	DD	
Хоёр нутагтан, мөлхөгчид					
27	Бамбай хоншоорт могой	*Glooydius halys*	--	LC	
28	Рашаан могой	*Coluber dione*	--	LC	

Эдгээр төрөл зүйлүүдэд төслийн үйл ажиллагааны явцад хөнөөл учруулахыг хатуу хориглох бөгөөд дараах хамгааллын арга хэмжээг Монгол улсад мөрдөн ажиллаж байна:

ХҮСНЭГТ 29. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ДАХЬ ЗАРИМ ЗҮЙЛИЙН ХӨХТӨНИЙ ХАМГААЛАЛТЫН ХЭЛБЭР

№	Зүйлийн нэр	Ховордлын шалтгаан	Хамгааллын хэлбэр
1	Цоохор ирвэс	Арьс болон ясыг Хятадын ардын эмнэлэгт барын ясны оронд ашиглах зорилгоор хууль бусаар агнадаг (Liao, Tan, 1988). Мөн махыг нь эмийн түүхий эд болгодог.	ХЗОХК-ын Хавсралт I-д орсон (UNEP-WCMC, 2006). Монгол улсын амьтны аймгийн тухай хуулийн 7.1д (2000) нэн ховор зэрэглэлд оруулсан (Бадам, Ариунзул, 2005). 1972 оноос хойш агнахыг хуулиар хориглосон, 1995 оны ан агнуурын тухай хуулиар нэн ховор зүйлийн жагсаалтанд оруулсан (БОЯ, 1996).
2	Аргаль хонь	Хууль бус агнуур, эврийн төлөөх гадаадын анчдын тогтвортой бус (тооцоонд үндэслээгүй) агнуур энэ зүйлийн ховордлын гол шалтгаан болж байна	Монгол улсын амьтны аймгийн тухай хуулинд (2000) өөрчлөлт оруулж (2001) (засгийн газрын тогтоол [1]264) ховор зэрэглэлээр хамгаалсан (Бадам, Ариунзул, 2005). Агнахыг 1953 оноос хойш хуулиар хориглосон. Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар ховор зүйлийн жагсаалтанд орсон (БОЯ, 1996). ХЗОХК-ын Хавсралт II-т орсон.
3	Хар сүүлтий	Олзвор агнуураас гадна махыг нь ашиглах зорилгоор хууль бусаар агнаж байгаа нь ховордох гол шалтгаан юм.	Монгол улсын амьтны аймгийн тухай хууль (2000), Засгийн газрын тогтоолоор (2001 оны [1]264) ховор зэрэглэлээр хамгаалсан (Бадам, Ариунзул, 2005). Монгол улсын ан агнуурын тухай 1995 оны хуулиар энэ зүйлийг ховор зэрэглэлд оруулсан (БОЯ, 1996).
4	Монгол тарвага	Дотоодын болон гадаадын зах зээлд гаргахаар мах, арьс, ардын эмнэлэгт ашиглах зорилгоор агнадаг. Тарваганы тос кортикостероне2 их хэмжээгээр агуулдаг ба хүүхэд, амьтанд хүнсний нэмэлт тэжээл байдлаар хэрэглэдэг, мөн түлэнхий, хөлдөлт, анемиа, сүрьеэ, арьсны өвчинд хэрэглэж ирсэн уламжлалтай[10]. Өнгөрсөн зууны 1906 оноос 1994 оны хооронд Монголд нийт 104,2 сая тарваганы арьс олзворложээ[11] . Сүүлийн үед хийгдсэн агнуурын судалгааны мэдээгээр тухайн жилд тогтоосон агнуурын хяналтын тооноос даруй гурав дахин их тарваганы арьс арилжаалагдсан тоо баримт байгаа бөгөөд хууль бусаар 2004 онд бэлтгэсэн 117,000 гаруй тарваганы арьсыг	Байгаль Орчны Яамны сайдын тушаалаар 2005, 2006 онд орон даяар тарваганы агнуурыг бүрэн хориглосон. Урьд нь популяцийн тоо толгойноос хамааран наймдугаар сарын 10-аас аравдугаар сарын 15 хүртэлх хугацаанд тарвага агнахыг хуулиар зөвшөөрдөг байсан (БОЯ, 2005). Мөн түүнчлэн орон нутгийн засаг захиргаанд дөрвөн жил тутам судалгаа хийх, энэ зүйлийг хамгаалахын тулд тухайн газар нутгийн агналтыг хаах эрхийг хуулиар олгосон байна. Агнуурын гол нутагт (зөвшөөрөгдсөн тохиолдолд) агнуурын үйл ажиллагаа явуулдаг компанийн өөрсдийн хөрөнгөөр нь жил бүр судалгаа хийлгэсэн байх ёстой (Wingard, Zahler, 2006). Монгол

[10] *Адъяа, 2000*
[11] *Батболд, 1996*

		улсын орлого болгожээ (Zahler нар, 2004). Тахал өвчин дэлгэрэх нь тоо толгойн хорогдолын шалтгааны нэг бөгөөд тарвага агнах явцад хүн тарваган тахлын нянгаар халдварладгийг тогтоосон учраас устгахыг оролддог[12]. Гэсэн хэдий ч популяцийн тоо толгой буурах хэрээр тахал гарах давтамж буурдаг байна.	тарваганы тархац нутгийн 6 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.Байгаль Орчны Яамны сайдын тушаалаар 2005, 2006 онд орон даяар тарваганы агнуурыг бүрэн хориглосон. Урьд нь популяцийн тоо толгойноос хамааран наймдугаар сарын 10-аас аравдугаар сарын 15 хүртэлх хугацаанд тарвага агнахыг хуулиар зөвшөөрдөг байсан (БОЯ, 2005). Мөн түүнчлэн орон нутгийн засаг захиргаанд дөрвөн жил тутам судалгаа хийх, энэ зүйлийг хамгаалахын тулд тухайн газар нутгийн агналтыг хаах эрхийг хуулиар олгосон байна. Агнуурын гол нутагт (зөвшөөрөгдсөн тохиолдолд) агнуурын үйл ажиллагаа явуулдаг компанийн өөрсдийн хөрөнгөөр нь жил бүр судалгаа хийлгэсэн байх ёстой (Wingard, Zahler, 2006). Монгол тарваганы тархац нутгийн 6 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагдсан.
5	Хярс	Үслэг арьс, мах зэрэг бүтээгдэхүүн нь бага үнэтэй ч хараа хяналтгүй агнуур газар авсаар байна. Дорнод Монгол болон Монгол Дагуурын хээрт 2001, 2002, 2003 онуудад үлийн цагаан оготны (Lasiopodomys brandti) тоо толгойг зохицуулахад хэрэглэж буй Бромадиолоне химийн хорт бодисонд дам өртөж хорогдох нь бий. Гэсэн хэдий ч энэ үйл ажиллагаа одоогоор зогссон ч бусад зүйлд нөлөөлсөөр байна (Н. Батсайхан, аман мэдээ). Байгалийн нөөцийн олборлолтын (уул уурхай) идэвхтэй үйл ажиллагаа өссөнөөс амьдрах орчны хомсдол бий болж байна. Гэрийн нохойнд дайруулахаас гадна галзуу өвчинд нэлээд өртөмтгий (Гептнер нар, 1967).	Аравдугаар сарын 21-нээс дараа оны хоёрдугаар сарын 16 хүртэлх хугацаанд агнахыг хуулиар зөвшөөрсөн (БОЯ, 2005). Засгийн газрын тогтоолоор олзвор агнуурын зөвшөөрлийн үнэлгээг 55 ам. доллараар тогтоосон (MNE, 2005). Монгол улсын байгалийн нөөцийг ашигласны төлбөрийн тухай хуулиар тодорхой хувийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна (Wingard, Zahler, 2006). Хярсны тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газарт хамрагддаг.

[12] *Batbold, 2002*

Иймд “Тахь ресурс” ХХК нь (i) амьтдын амьдрах орчныг алдагдуулахгүй байх, (ii) төслийн ажилчид хууль бус ан агнуур хийлгэхгүй байх, урьдчилан сэргийлэхэд онцгойлон анхаарч ажиллах, (iii) тус төсөлд зэрлэг амьтдад хор хөнөөлтэй, гэмтээх хашаа хайс байршуулахгүй байх (iv) тусгай зөвшөөрлийн талбайн гадна хор хөнөөл учруулахгүй байх шаардлагатай.

Хярс *Гэрэл зургийг: Gogo.mn*	Монгол тарвага *Гэрэл зургийг: Л. Гантогтох*
 Гэрэл зургийг: apittet	 *Гэрэл зургийг: Л. Гантогтох*

ШУВУУД

Монгол орны хэмжээнд нийт 502 зүйл шувуу нүүдлийн, хагас нүүдлийн болон суурин байдлаар амьдардаг. Төслийн талбай орчмын бүсэд нийт 110 орчим зүйл шувуу багтаж байгаа. Үүний дийлэнх хувь нь нүүдлийн болон улирлын онцлогтой байршдаг зүйл шувууд юм. Энэ орчны бүс нутагт тохиолдох шувуудын бүс нутгийн болон олон улсын үнэлгээгээр анхааралд өртөхөөргүй байна. Олон улсын үнэлгээгээр эмзэг ангилалд 2 зүйл, устаж болзошгүй ангилалд 2 зүйл, ховордож болзошгүй ангилалд 6 зүйл байна.

ЗУРАГ 29. ЦАРМЫН БҮРГЭД (2024 ОНЫ ХЭЭРИЙН СУДАЛГАА)

ХҮСНЭГТ 30. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧИМ ТОХИОЛДОХ ШУВУУДЫН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ БА ХАМГААЛЛЫН СТАТУС

№	Түгээмэл нэр	Шинжлэх ухааны нэршил	Бүс нутгийн үнэлгээ	Олон улсын үнэлгээ
1	Отгот шунгуур	*Podiceps cristatus*	АӨ	АӨ
2	Хөх дэглий	*Ardea cinerea*	АӨ	АӨ
3	Гангар хун	*Cygnus cygnus*	АӨ	АӨ
4	Ногоохон нугас	*Anas crecca*	АӨ	АӨ
5	Зэрлэг нугас	*Anas platyrhynchos*	АӨ	АӨ
6	Анхидал ангир	*Tadorna tadorna*	АӨ	АӨ
7	Халбага нугас	*Spatula clypeata*	АӨ	АӨ
8	Цагаан хөмсөгт нугас	*Spatula querquedula*	АӨ	АӨ
9	Шовтгор алаг нугас	*Anas acuta*	АӨ	АӨ
10	Зээрд нугас	*Mareca penelope*	АӨ	АӨ
11	Бор нугас	*Mareca strepera*	АӨ	АӨ
12	Улаан хүзүүт шумбуур	*Aythya ferina*	АӨ	Э
13	Гэзэгт шумбуур	*Aythya fuligula*	АӨ	АӨ
14	Ооч ёл	*Gwpaetus barbatus*	Э	ХБ
15	Саарал хулд	*Circus cyaneus*	АӨ	АӨ
16	Сохор элээ	*Milvus migrans*	АӨ	АӨ
17	Нөмрөг тас	*Aegypius monachus*	АӨ	ХБ

18	Хималайн хажир	*Gyps himalayensis*	АӨ	ХБ
19	Талын сар	*Buteo rufinus*	АӨ	АӨ
20	Ойн сар	*Buteo buteo*	АӨ	АӨ
21	Морин харцага	*Accipiter nisus*	АӨ	АӨ
22	Начин шонхор	*Falco tinnunculus*	АӨ	АӨ
23	Зээрд шонхор	*Falco naumanni*	АӨ	АӨ
24	Цармын бүргэд	*Aquila chrysaetos*	АӨ	АӨ
25	Тарважи бүргэд	*Aquala nipalensis*	АӨ	УБ
26	Шилийн сар	*Buteo hemilasius*	АӨ	АӨ
27	Идлэг шонхор	*Falco cherrug*	УБ	Э
28	Шууман шонхор	*Falco subbuteo*	АӨ	АӨ
29	Амарын шонхор	*Falco amurensis*	АӨ	АӨ
30	Дагуур ятуу	*Perdix dauurica*	АӨ	АӨ
31	Өвөгт тогоруу	*Arthropoides virgo*	АӨ	АӨ
32	Нарийн хиазат	*Charadrius dubius*	АӨ	АӨ
33	Азийн сүвээ цагаан	*Pluvialis fulva*	АӨ	АӨ
34	Умардын хавтгаалж	*Vanellus vanellus*	АӨ	ХБ
35	Халзан түнжүү	*Fulica atra*	АӨ	АӨ
36	Шар түрүүт элсэг	*Calidris ruficollis*	АӨ	ХБ
37	Одой элсэг	*Calidris minuta*	АӨ	АӨ
38	Алаг хайргач	*Arenaria interpres*	АӨ	АӨ
39	Тэнгисийн хиазат	*Charadrius alexandrinus*	АӨ	АӨ
40	Дорнын хиазат	*Charadrius veredus*	АӨ	АӨ
41	Зэвэн хиазат	*Charadrius leschenaultii*	АӨ	АӨ
42	Сүүл элсэг	*Calidris acuminata*	АӨ	АӨ
43	Хадуур элсэг	*Calidris ferruginea*	АӨ	ХБ
44	Темминскийн элсэг	*Calidris temminckii*	АӨ	АӨ
45	Савар элсэг	*Calidris subminuta*	АӨ	АӨ
46	Хар хөгчүү	*Tringa erythropus*	АӨ	АӨ
47	Улаан хөлт хөгчүү	*Tringa totanus*	АӨ	АӨ
48	Үхэр хөгчүү	*Tringa nebularia*	АӨ	АӨ
49	Шугуйн хөгчүү	*Tringa glareola*	АӨ	АӨ
50	Цагаан сүүлт хөгчүү	*Tringa ochropus*	АӨ	АӨ
51	Хайргын хөгчүү	*Actitis hypoleucos*	АӨ	АӨ
52	Бүрдний хөгчүү	*Tringa stagnatilis*	АӨ	АӨ
53	Замбын хараалж	*Gallinago stenura*	АӨ	АӨ
54	Шөвгөн хараалж	*Gallinago gallinago*	АӨ	АӨ
55	Монгол цахлай	*Larus argentatus*	АӨ	АӨ
56	Хүрэн толгойт цахлай	*Larus ridibundus*	АӨ	АӨ
57	Буурал хараалзай	*Chlidonias leucopterus*	АӨ	АӨ
58	Хадны тагтаа	*Columba rupestris*	АӨ	АӨ
59	Хөхвөр тагтаа	*Columba livia*	АӨ	АӨ
60	Монгол ногтруу	*Syrrhaptes paradoxus*	АӨ	АӨ

61	Эгэл шар шувуу	*Bubo bubo*	АӨ	АӨ
62	Эгэл хөхөө	*Culculus canorus*	АӨ	АӨ
63	Дорнын хүүрзгэнэ	*Streptopelia orientalis*	АӨ	АӨ
64	Хотны бүгээхэй	*Athene noctua*	АӨ	АӨ
65	Холтсон гоётуул	*Jynx torquilla*	АӨ	АӨ
66	Бөвөөлжин өвөөлж	*Upupa epops*	АӨ	АӨ
67	Хондлой цагаан ураацай	*Apus pacificus*	АӨ	АӨ
68	Хурын ураацай	*Apus apus*	АӨ	АӨ
69	Монгол болжмор	*Melonocorypha mongolica*	АӨ	АӨ
70	Асрын алтанхараацай	*Hirundo rustica*	АӨ	АӨ
71	Боролзой болжмор	*Alauda arvensis*	АӨ	АӨ
72	Согсоот болжмор	*Galerida cristata*	АӨ	АӨ
73	Дэрсний жиргэмэл	*Calandrella cheleensis*	АӨ	АӨ
74	Хээрийн шийхнүүхэй	*Anthus richardi*	АӨ	АӨ
75	Хөх цэгцгий	*Motacilla alba*	АӨ	АӨ
76	Уулын цэгцгий	*Motacilla cinerea*	АӨ	АӨ
77	Шар цэгцгий	*Motacilla flava*	АӨ	АӨ
78	Харзны шийхнүүхэй	*Anthus spinoletta*	АӨ	АӨ
79	Бөртөт шийхнүүхэй	*Anthus hodgsoni*	АӨ	АӨ
80	Годлевскийн шийхнүүхэй	*Anthus godlewskii*	АӨ	АӨ
81	Үнсэн дунхай	*Lanius excubitor*	АӨ	АӨ
82	Тольт дунхай	*Lanius isabellinus*	АӨ	АӨ
83	Ухаа дунхай	*Lanius cristatus*	АӨ	АӨ
84	Сибирийн хайруулдай	*Prunella montonella*	АӨ	АӨ
85	Хадны жижир	*Monticola saxatilis*	АӨ	АӨ
86	Бүжимч чогчиго	*Oenanthe isabellina*	АӨ	АӨ
87	Цөлийн чогчиго	*Oenanthe deserti*	АӨ	АӨ
88	Мяраан чогчиго	*Pied wheatear*	АӨ	АӨ
89	Адууч чогчиго	*Oenanthe oenanthe*	АӨ	АӨ
90	Өнгөлүүрт гургалдай	*Luscinia calliope*	АӨ	АӨ
91	Дагуур галсүүлт	*Phoenicurus auroreus*	АӨ	АӨ
92	Улаан гүеэт хөөндэй	*Turdus ruficollis*	АӨ	АӨ
93	Цөлийн зэржигэнэ	*Sylvia nana*	АӨ	АӨ
94	Бүхт дууч шувуу	*Phylloscopus fuscatus*	АӨ	АӨ
95	Цагаан хэвэлж хөмрөг	*Emberiza pallasi*	АӨ	АӨ
96	Шар элэгт нөмрөг	*Emberiza aureola*	Э	УБ
97	Монгол алтанжигүүр	*Bucanetes mongolicus*	АӨ	АӨ
98	Улаан бор бужирга	*Carduelis flavirostris*	АӨ	АӨ
99	Хадны боршуу	*Petronia petronia*	АӨ	АӨ
100	Хээрийн бор шувуу	*Passer montanus*	АӨ	АӨ
101	Орончийн бор шувуу	*Passer domesticus*	АӨ	АӨ
102	Хар хэрээ	*Corvus corone*	АӨ	АӨ
103	Турлиах хэрээ	*Corvus frugilegus*	АӨ	АӨ

104	Улаан хошуут жунгаа	*Red billed chough*	АӨ	АӨ
105	Хондон ангир	*Tadorna ferruginea*	АӨ	АӨ
106	Эвэрт болжмор	*Eremophila alpestris*	АӨ	АӨ
107	Талын жиргэмэл	*Calandrella brachydactyla*	АӨ	АӨ
108	Хон хэрээ	*Corvus corax*	АӨ	АӨ
109	Монгол божирог	*Pyrgilauda davidiana*	АӨ	АӨ
110	Цасны богшоодой	*Montifringilla nivalis*	АӨ	АӨ

МӨЛХӨГЧ

ХҮСНЭГТ 31. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧИМ ТОХИОЛДОХ БОЛОМЖТОЙ МӨЛХӨГЧДИЙН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ

Зүйлийн нэр	ОУБХХ-ны ангилал	Хамгаалсан байдал	Тархац нутаг	Тоо толгой хомсдох шалтгаан
Бамбай хоншоорт могой *Gloydius halys* 	Үнэлгээ хийгдээгүй	Тархац нутгийн 12 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан[13][14]	Монгол орны говь цөл, уулын хээр, ойт хээр, ой хөвч зэрэг байгалийн үндсэн бүс бүслүүрт өргөн тархсан[15]	-Амьдрах орчны доройтол
Рашааны могой *Elaphe dione* 	Үнэлгээ хийгдээгүй	тархац нутгийн 10 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан.	Монгол орны говь, цөлийн бүсээс хойт хэсгийн ой тайга хүртэлх өргөн уудам нутагт, өндөр уулын бүсээс бусад байгалийн янз бүрийн бүс бүслүүрт тархан амьдарна[16][17]	-Хоол тэжээлийн хомсдол -Үнэг, хярс, махчин шувуудын хооллолт -Дэд бүтцийн байгууламж -Байгалийн нөөц, баялгийн хайгуул, ашиглалт, олборлолт -Хүний үйл ажиллагаа
Говийн гүрвэл *Eremias przewalskii* 	Үнэлгээ хийгдээгүй	Тархац нутгийн 18 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан	Монгол орны баруун болон өмнөд нутгийн цөлийн элсэрхэг хөрстэй нутгаар түгээмэл тархжээ	-Эмийн түүхий эд болгох -Амьдрах орчны хомсдол -Махчин амьтдын тоо толгойн өсөлт -Ган, зуд
Могой гүрвэл *Eremias multiocellata*	Үнэлгээ хийгдээгүй	Тархац нутгийн 18 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан	Энэ нь Монгол орны говь цөлийн бүс нутгаар түгээмэл тархсан	-Байгалийн нөөцийн олборлолт -Амьдрах орчин доройтох -Махчин амьтдын тоо толгойн өсөлт -Ган, зуд
Монгол гүрвэл *Eremias argus*	Үнэлгээ хийгдээгүй	Тархац нутгийн 8 орчим хувь нь	Энэ зүйл нь цөлөрхөг хээр, хээрийн бүсийн хуурай хэв шинжийн	Ховордлын талаар мэдээ баримт байхгүй.

[13] *UNEP-WCMC, 2006*
[14] Х. Тэрбиш нар 2006
[15] Мөнхбаяр, Тэрбиш, 1997
[16] *Мөнхбаяр, 1976б*
[17] *Ананьева нар, 1997*

		улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан	янз бүрийн амьдрах орчинд идээшин нутагшдаг	
Цоохор хонин гүрвэл *Phrynocephalus versicolor*	Үнэлгээ хийгдээгүй	Тархац нутгийн 18 орчим хувь нь улсын тусгай хамгаалалтай газар нутгийн сүлжээнд хамрагдсан	Говь цөлд хамгийн түгээмэл тохиолддог	-Ашигт малтмалаар хөрс хуулах, газар тариалангийн зориулалтаар хагалан боловсруулах явцад амьдрах орчин эвдэрч цоохор хонин гүрвэлийн тоо толгойд сөрөг нөлөөлнө.

13.5 Ургамлан нөмрөгийн мониторингийн судалгаа:

Ургамалжилын Судалгааны Арга Зүй

Ургамалжилтын мониторингийн хээрийн судалгааг 2025 оны 09 дүгээр сарын 24 нд хийж гүйцэтгэсэн.

Судалгааны зорилго: Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын үйл ажиллагааны явцад ургамлан бүрхэвчийн өөрчлөлт, доройтол ажиглагдаж байгаа эсэх, мөн хайгуулын талбайн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлоход ургамлын мониторингийн судалгааны зорилго оршино.

Судалгааны арга зүй: Мониторингийн ажлын хүрээнд хяналт шинжилгээний тогтоосон 10 цэг тус бүрт ургамлын бичиглэл хийн, зүйлийн бүрдлийг тодорхойлон, өөрчлөлт доройтлыг тогтоож, биомассын хэмжилт хийсэн. Геоботаникийн бичиглэл хийхийн тулд тухайн газарт 10х10 м2 , 1х1 м2 раменскийн тор татаж тус талбайд зүйл тус бүрээр нь бичиглэл хийж, хээрийн судалгааны мэдээ материал цуглуулан боловсруулалт хийсэн.

Геоботаникийн бичиглэлд:

Зүйлийн бүтэц, бүрэлдэхүүн: Ургамал бүлгэмдэл бүрт ургасан ургамлын нийт зүйлийг хээрийн судалгаагаар бүртгэж, фото зургийг авж тодорхойлох боломжгүй зүйлийг бичиглэлийн хуудсанд кодлон бичээд, тус зүйлийн хатаамал хийж, лабораторид тодорхойлсны дараа нэрийг нь бичсэн. Ургамал тодорхойлохдоо И.В. Грубов (2008), Н. Өлзийхутаг (1985), болон бусад (Flora of China, 2019) эх сурвалжийг ашиглав. Ургамлынзүйлийг “Монгол орны биологийн олон янз байдал: ургамал, мөөг, бичил биетний зүйлийн жагсаалт”-нд зааснаар (Ургамал нар, 2019) нэрлэсэн.

ЗУРАГ 30. УРГАМЛЫН ХЭЭРИЙН СУДАЛГАА АВЧ БУЙ БАЙДАЛ

Арви: Ургамалжлын зүйлийн арвид О.Друдегийн нүдэн баримжааны аргаар үнэлгээг өгсөн.
Тусгаг бүрхэц: Тусгагийн бүрхэц (цаашид бүрхэц хэмээв) нь аливаа биетийн газрын гадаргуу дээрх тусгалын проекц юм. Бүлгэмдлийн нийт бүрхэц, халцгай газар, хагд болон зүйл тус бүрийн бүрхцийг 1 м х 1 м хэмжээтэй тор ашиглан хувиар үнэлж, гэрэл зургаар баталгаажуулав.
Өсөлт: Ургамлын өсөлтийг тодорхойлохын тулд өндрийг сантиметрийн хэмжээст шугамаар газрын хөрснөөс дээш 0 см-ийн өндөрт 3 удаагийн давталттай хэмжсэн.
Ургац: Зүйлийн бүрэлдэхүүн цөөн, ургамалжил шигүү биш байхад 1м^2 хэмжээгээс дээж авах тохиромжтой18. Ургамлыг зүйл тус бүрээр газрын гадаргын түвшинд хайчлан авч, цаасан уутанд хийнэ. Хээрээс цуглуулсан дээжээ тасалгааны температурт 2-3 долоо хоног хатаана. Харьцангуй хуурай жинг 0.01-0.05 гр-ийн нарийвчлалтай электрон жингээр тодорхойлно.

[18] *Геоботаник УБ 2005*

ЗУРАГ 31. ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ ДЭЭЖ БЭЛТГЭЖ БУЙ БАЙДАЛ

Дэлгэр хайгуулын талбайн ургамлан нөмрөг

Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын Дэлгэр талбайн дийлэнх хэсэг хуурай хээрийн бүсэд хамаарах бөгөөд *(i) Хялгана-ерхөгт, (ii) Харгана-шарилж оролцсон хялгана-хазаар өвст, (iii) Хялгана-таанат*, *(iv) Хялгана-таана-баглуурт, (v) Ерхөг-хялгана-алаг өвст, (v) Ерхөг-хялгана-алаг өвст, (vi) Шарилж-хунчир оролцсон ерхөг-хялгана-алаг өвст* бүлгэмдлүүд тархжээ.

ЗУРАГ 32. БОГД-IV ХАЙГУУЛЫН ТАЛБАЙН УРГАМАЛЖЛЫН СУДАЛГААНЫ ЦЭГҮҮД

ТӨСЛИЙН ТАЛБАЙН ЗҮЙЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ургамал, түүнээс ялангуяа зүйлийн бүрэлдэхүүн нь байгалийн онгон төрхөөрөө байгаа эсэхээс эхлэн түүний шим нөөцийн чадавхын заагуур болно[19]. 2023 оны Дэлгэр талбай орчмын судалгааны дүнгээс 8 зүйл, 2024 оны ургамалжлын мониторинг судалгаанд нийт 7 овгийн 11 төрлийн 13 зүйл, 2025 оны ургамалжлын мониторинг судалгаанд нийт 6 овгийн 9 төрлийн 9 зүйл бүртгэгдсэн. Төрөл зүйлийн тоо бүрхэц, нягтшил нь тухайн жилийн цаг агаарын онцлогоос ихээхэн хамааралтай байдаг учир тухайн жилийн онцлог хээрийн судалгааны цаг үеэс хамаарч ургамлын төрөл зүйлийн тоо бага зэрэг өөрчлөгдөж болох бөгөөд мөн судалгааны цэгийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

ХҮСНЭГТ 32. ТЭМДЭГЛЭГДСЭН УРГАМЛЫН ЗҮЙЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Түгээмэл нэр	Тэмдэглэгдсэн он			Шинжлэх ухааны нэр	Аж ахуйн бүлэг
1	Ширэг өлөн		*2024*	*2025*	*Carex duriuscula*	Улалж
2	Амманы сэдэргэнэ	*2023*	*2024*		*Convolvulus ammannii*	Алаг өвс
3	Саман ерхөг		*2024*	*2025*	*Agropyron cristatum*	Үетэн
4	Үндсэрхэг сонгино	*2023*	*2024*	*2025*	*Allium polyrhizum*	Алаг өвс
5	Гялгар дэрс		*2024*	*2025*	*Neotrinia splendens*	Үетэн
6	Адамсын шарилж		*2024*	*2025*	*Artemisia adamsii*	Алаг өвс

[19] *Манибазар, 1999*

7	Сантолин навчит шарилж		*2024*		*Artemisia santolinifolia*	Алаг өвс
8	Сайрын хялгана	*2023*	*2024*	*2025*	*Stipa caucasica* subsp. *glareosa*	Үетэн
9	Крыловын хялгана		*2024*	*2025*	*Stipa krylovii*	Үетэн
10	Дэлгээ мананхамхаг	*2023*	*2024*		*Bassia prostrata*	Алаг өвс
11	Ахар навчит баглуур	*2023*	*2024*	*2025*	*Anabasis brevifolia*	Сөөг
12	Орог тэсэг		*2024*		*Kraschnikovia ceratoides*	Сөөг
13	Үхэр шүлхэй		*2024*	*2025*	*Neopallasia pectinata*	Цөөн наст

ТӨСЛИЙН ТАЛБАЙН УРГАМЛАН БҮЛГЭМДЭЛ

Төслийн талбай орчим хуурай хээр болон цөлжүү хээрийн ургамалжилтай. Цөлийн хээрийн умрад хэсэг буюу хуурай хээрээс цөлийн хээрт шилжих завсрын бүсэд хуурай хээрийн (*Agroperon cristatum, Stipa krylovii, Cleistogenes squarrosa, Koeleria macrantha*) болон цөлийн хээрийн (*Stipa glareosa, Allium polyrrhizum*) ноёлогч ургамлууд холилдон ургаж бүлгэмдэл үүсгэдэг. Эдгээр ургамлан бүлгэмдлүүд хуурай ба цөлийн хээрийн завсрын шинжтэй байдаг тул аль алинд нь оруулалгүй завсрын цөлжүү хээр болгон авдаг (И.Түвшинтогтох, 2014.). Төслийн талбай орчмын ургамалжил нь цөлөрхөг хээрийн ургамалжилттай бөгөөд зонхилогч нь дэгнүүлт ургамал хялгана *Stipa*, сонгино *Allium* зонхилхоос гадна цөлийн сөөг, сөөгөнцөр ургамал болох харгана *Caragana*, шаваг *Artemisia* баглуур *Anabasis brevifolia* бударгана *Salsola* зэрэг бутлаг ургамлууд зонхилон тохиолдоно.

<u>Төслийн талбайн 2025 оны төлөв байдал</u>

Ургамлын хээрийн судалгааг хийхдээ экологи, ургамлан бүлгэмдлийн бүтэц бүрэлдэхүүн онцлогоос харгалзан төслийн талбайд хэмжилт судалгааг явуулсан. Ургамлын судалгааг 2025 оны 9 дугаар сард ургамлын 10 бүрэн бичиглэл хийж зүйлийн бүрэлдэхүүн, ургамлан бүрхэвч, биомасс зэргийг тодорхойлсон.

DL25-01D-01 ТАЛБАЙН УРГАМЛЫН БИЧИГЛЭЛ

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар – DL25-01D-01 (N: $46^0$14'33" E: $97^0$16'3")

Сайрын хялгана (*Stipa glareosa*) зонхилсон. Бүлгэмдлийн ургамал ургалтын үеийн дундаж өндөр 3-8 см ба энэхүү бүлгэмдэл өвслөг ургамлын 1 ташинга үүсгэдэг. Ургамлын өндрийн үеллээр (босоо бүтэц) авч үзвэл 1 үеллийг үүсгэнэ. Хүн, мал амьтны нөлөө 4 дугаар шатлал. Хур тунадасны усаар хангагдана. Төслийн талбай орчмын ургамал бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц дунджаар 30% байх бөгөөд 10 метр квадратад дунджаар 1 зүйл ургамалтай. 9 дугаар сарын байдлаар 0.4 ц/га ургацтай. 9-р сарын 2 дугаар 10 хоногийн байдлаар бүлгэмдлийн зүйлүүд фенологийн хувьд хагдралтын дунд үед байв.

ЗУРАГ 33. DL25-01D-01 ТАЛБАЙ

Цэгийн гадаргын ерөнхий байдал: Тэгш тал
Бүлгэмдлийн хэв шинж: хялганат

Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 30 %, хайрга чулуун бүрхэвч 10 %, хагдан бүрхэвч 30 %, ил хөрс 40% орчим байна.

ЗУРАГ 34. DL25-01D-01 ТАЛБАЙН ӨНӨӨГИЙН ТӨРХ

ХҮСНЭГТ 33. DL25-01D-01 ТАЛБАЙН УРГАМЛАН БҮЛГЭМДЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Бүлгэмдлийн нэр	Зонхилох зүйл /1 м^2/	Арви	Бүрхэц
Хялганат	*Stipa glareosa*	*Soc*	25

DL25-01D-02 ТАЛБАЙН УРГАМЛЫН БИЧИГЛЭЛ

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар – Dl25-01D-02 (N: 46^{0}14'35" E: 97^{0}14'40") Үндсэрхэг сонгино (*Allium polyrhizum*) зонхилж Сайрын хялгана (*Stipa glareosa*) зэрэг тархдаг. Бүлгэмдлийн ургамал ургалтын үеийн дундаж өндөр 5-8 см ба энэхүү бүлгэмдэл өвслөг ургамлын 1 ташинга үүсгэдэг. Ургамлын өндрийн үеллээр (босоо бүтэц) авч үзвэл 1 үеллийг үүсгэнэ. Хүн, мал амьтны нөлөө 4 дугаар шатлал. Хур тунадасны усаар хангагдана. Төслийн талбай орчмын ургамал бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц дунджаар 30% байх бөгөөд 10 метр квадратад дунджаар 2 зүйл ургамалтай. 9 дүгээр сарын байдлаар 0.5 ц/га ургацтай. 9-

р сарын 2 дугаар 10 хоногийн байдлаар бүлгэмдлийн зүйлүүд фенологийн хувьд хагдралтын үед байв.

ЗУРАГ 35. DL25-01D-02 ТАЛБАЙ

Цэгийн гадаргын ерөнхий байдал: Тэгш тал
Бүлгэмдлийн хэв шинж: хялгана-таанат

Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 30 %, хайрга чулуун бүрхэвч 5 %, хагдан бүрхэвч 30%, ил хөрс 60 % орчим байна.

ЗУРАГ 36. DL25-01D-02 ТАЛБАЙН ӨНӨӨГИЙН ТӨРХ

ХҮСНЭГТ 34. DL25-01D-02 ТАЛБАЙН УРГАМЛАН БҮЛГЭМДЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Бүлгэмдлийн нэр	Зонхилох зүйл /1 м^2/	Арви	Бүрхэц
Хялгана-таанат	*Allium polyrhizum*	*Cop3*	20
	Stipa glareosa	*Cop2*	10

DL24-01D-01 ТАЛБАЙН УРГАМЛЫН БИЧИГЛЭЛ

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар – Dl24-01D-01 (N: 46^{0}10’33” E: 97^{0}15’56”) Сайрын хялгана (*Stipa glareosa*), Крыловын хялгана (*Stipa krylovii*) нар зонхилж Дэлхээ мананхамхаг (*Bassia dasyphylla*), Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*), Амманийн сэдэргэнэ (*Convoluvlus ammannii*) зэрэг тархдаг. Бүлгэмдлийн ургамал ургалтын үеийн дундаж өндөр 6-15 см ба энэхүү бүлгэмдэл өвслөг ургамлын 1 ташинга үүсгэдэг. Ургамлын өндрийн үеллээр (босоо бүтэц) авч үзвэл 1 үеллийг үүсгэнэ. Хүн, мал амьтны нөлөө 4 дугаар шатлал. Хур тунадасны усаар хангагдана. Төслийн талбай орчмын ургамал бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц дунджаар 40% байх бөгөөд 10 метр квадратад дунджаар 3 зүйл

ургамалтай. 9 дүгээр сарын байдлаар 2.3 ц/га ургацтай. 9-р сарын 2 дугаар 10 хоногийн байдлаар бүлгэмдлийн зүйлүүд фенологийн хувьд хагдралтын үед байв.

ЗУРАГ 37. DL24-01D-01 ТАЛБАЙ

Цэгийн гадаргын ерөнхий байдал: Тэгш тал
Бүлгэмдлийн хэв шинж: хялгана-таана-бударганат
Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 40 %, хайрга чулуун бүрхэвч 2 %, хагдан бүрхэвч 40 %, ил хөрс 50 % орчим байна.

ЗУРАГ 38. DL24-01D-01 ТАЛБАЙН ӨНӨӨГИЙН ТӨРХ

ХҮСНЭГТ 35. DL24-01D-01 ТАЛБАЙН УРГАМЛАН БҮЛГЭМДЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Бүлгэмдлийн нэр	Зонхилох зүйл /1 м²/	Арви	Бүрхэц
Хялгана-таана-бударгана	*Anabasis brevifolia*	*Cop2*	10
	Allium polyrhizum	*Cop2*	20
	Stipa glareosa	*Sol*	2

DL23-03D-01 ТАЛБАЙН УРГАМЛЫН БИЧИГЛЭЛ

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар – DL23-03-01 (N: $46^0$12’1” E: $97^0$17’20”) Үндсэрхэг сонгино (*Allium polyrhizum*) зонхилж, Сайрын хялгана (*Stipa glareosa*), Ахар навчит баглуур (Anabasis brevifolia) зэрэг тархдаг. Бүлгэмдлийн ургамал ургалтын үеийн дундаж өндөр 2-10см ба энэхүү бүлгэмдэл өвслөг ургамлын 1 ташинга үүсгэдэг. Ургамлын өндрийн үеллээр (босоо бүтэц) авч үзвэл 1 үеллийг үүсгэнэ. Хүн, мал амьтны нөлөө 4 дугаар шатлал. Хур тунадасны усаар хангагдана. Төслийн талбай орчмын ургамал бүлгэмдлийн ерөнхий тусгагийн бүрхэц дунджаар 30% байх бөгөөд 10 метр квадратад дунджаар 3 зүйл ургамалтай.

9 дүгээр сарын байдлаар 0.3 ц/га ургацтай. 9-р сарын 2 дугаар 10 хоногийн байдлаар бүлгэмдлийн зүйлүүд фенологийн хувьд хагдралтын үед байв

ЗУРАГ 39. DL23-03D-01 ТАЛБАЙ

Цэгийн гадаргын ерөнхий байдал: Тэгш тал
Бүлгэмдлийн хэв шинж: хялгана-таана-бударганат
Ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 30 %, хайрга чулуун бүрхэвч 4 %, хагдан бүрхэвч 30 %, ил хөрс 60 % орчим байна.

ЗУРАГ 40. DL23-03D-01 ТАЛБАЙН ӨНӨӨГИЙН ТӨРХ

ХҮСНЭГТ 36. DL23-03D-01 ТАЛБАЙН УРГАМЛАН БҮЛГЭМДЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Бүлгэмдлийн нэр	Зонхилох зүйл /1 м²/	Арви	Бүрхэц
Хялгана-таанат	*Anabasis brevifolia*	*Sol*	3
	Allium polyrhizum	*Cop2*	15
	Stipa glareosa	*Cop2*	10

САМР-2024 ТАЛБАЙН УРГАМЛЫН БИЧИГЛЭЛ

Геоботаникийн бичиглэл хийсэн цэгийн дугаар – Camp 2024 (N: 46^{0}11’35” E: 97^{0}17’3”)

